

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-21</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>22-66</i>
<hr/>	
<i>1. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.31-ний өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/</i>	<i>23-43</i>
<i>2. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/</i>	<i>43-49</i>
<i>3. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>49-66</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
11 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 57 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Т.Аубакир, Г.Мөнхцэцэг, Д.Өнөрболор;

Чөлөөтэй: Б.Бейсен, Х.Болорчулуун;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Саранчимэг.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв.

Нэг.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.31-ний өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал харицсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга Ж.Ичинноров, мөн албаны Газар чөлөөлөх хэлтсийн дарга Н.Мөнхбаяр, Нийслэлийн орон сууцны бодлогын газрын дарга Г.Ганхүү, Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Д.Хан-Уул, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч Д.Авирмэд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж УТҮГ-ын захирал Ч.Батзориг, Нийслэлийн Орон сууцны корпораци ХК-ийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Н.Ганибал, Г.Дамдинням, Т.Энхтүвшин, Г.Ганболд, Ж.Батжаргал, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3, 4, 5, 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал харицсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга Ж.Ичинноров, мөн албаны Газар чөлөөлөх хэлтсийн дарга Н.Мөнхбаяр, Нийслэлийн орон сууцны бодлогын газрын дарга Г.Ганхүү, Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Д.Хан-Уул, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч Д.Авирмэд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж УТҮГ-ын захирал Ч.Батзориг, Нийслэлийн Орон сууцны корпораци ХК-ийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Туваан, Т.Энхтүвшин, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Нийслэлийн Мал эмнэлгийн газрын Мал, амьтны эрүүл мэндийн хэлтсийн дарга Ц.Гантөмөр, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнхжаргал, “Азтай савар” төрийн бус байгууллагын тэргүүн Ц.Зориглон, мөн байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн Ц.Болормаа, эрх зүйч Э.Анударь, “Эм-Ди-Эс Энд ХаанЛекс” хуулийн фирмийн хуульч М.Ариунзул, “Монгол банхар” судлалын төвийн үүсгэн байгуулагч Д.Цэрэнханд, Монголын нохой судлалын холбооны тэргүүн А.Наранбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Д.Цогтбаатар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төслийн 3, 40, 47 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Ж.Батжаргал, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Д.Цогтбаатар, Азтай савар төрийн бус байгууллагын тэргүүн Ц.Зориглон, “Легал гайд” хуулийн фирмийн эрх зүйч Н.Баясгалан нар хариулж, тайлбар хийв.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Т.Аубакир, Э.Батшугар, Г.Дамдинням, Ц.Туваан /цаашид “ажлын хэсэг” гэх нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль,” гэсний дараа “Иргэний хууль, Зөвшөөрлийн тухай хууль,” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.3 дахь хэсэг нэмэх:

“2.3.Энэ хууль албаны нохойтой холбоотой харилцаанд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.2.“асран хамгаалагч” гэж гэрийн тэжээвэр амьтныг энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн хоол, орон байраар хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах болон нохой, муурыг өөрийн нэр дээр бүртгүүлсэн иргэнийг;

3.1.6.“түр байрлуулан асрамжлах газар” гэж төөрсөн, олдсон нохой, муурыг асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх хүртэл, эзэнгүй нохой, муурыг асран хамгаалагчтай болгох хүртэл хоол, орон байраар хангаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулан түр хараа хяналтдаа байлгах зорилгоор энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5

Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.8, 3.1.9, 3.1.10 дахь заалт нэмэх:

“3.1.8.“нохой, муур үржүүлэх” гэж нохой, муурыг нэг болон түүнээс дээш удаа үржүүлэхийг;

3.1.9.“нохой, муурын нэгдсэн бүртгэл” гэж нохой, муурын асран хамгаалагч, нохой муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагааг;

3.1.10.“Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж” гэж гэрийн тэжээвэр амьтанд урьдчилан сэргийлэх арга хэмжээ, оношилгоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нохой, мууранд үржил хязгаарлах мэс ажилбар хийх, бичил чип суулгах, шаардлагатай тохиолдолд унтуулах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан нэгжийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням санал хураалтаас хоцорсон тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд баримтлах зарчим

4.1.Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд дараах зарчмыг баримтална:

- 4.1.1 .энэрэнгүй хандах;
- 4.1.2.хүчирхийллээс ангид байлгах;
- 4.1.3.байгалиасаа өөрийн онцлогтой болохыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, халамжлах;

4.1.4.гэрийн тэжээвэр амьтныг гэршүүлэн тэжээж ирсэн Монголын ард түмний уламжлалт ахуй, ёс заншил, өв соёлын салшгүй нэг хэсэг болох үндэсний уугуул үүлдрийн нохойтой холбоотой өвөрмөц аж төрөх ёс, түүхэн уламжлалыг хадгалах, нандигнан өвлүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар бүлгийн гарчгийг “**ХОЁРДУГААР БҮЛЭГ.ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ АСРАН ХАМГААЛАГЧ БОЛОХ ҮНДЭСЛЭЛ, АСРАН ХАМГААЛАГЧ, ТҮР ХАРАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**” гэж өөрчилж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Иргэнд гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч болох үндэслэл дараах байдлаар үүснэ:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “6.1-д заасан шаардлагаас гадна асран хамгаалагчийн” гэснийг “7 дугаар зүйлд заасан” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.3 дахь хэсэг нэмэх:

“6.3.Иргэн гэрийн тэжээвэр амьтны талаарх ойлголт авах зорилгоор сайн дураараа асран хамгаалагчийн сургалтад хамрагдаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “энэ хуулийн” гэсний өмнө “хот, суурин газарт” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.4 дэх хэсэг нэмэх:

“7.4.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь хот, сууринаас бусад газарт энэ хуулийн 7.3-т заасан агуулга бүхий зөвлөмж, мэдээллийг өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “хууль буюу гэрээгээр олгогдсон” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1.2 дахь заалтын “хуульд заасны дагуу бусдад” гэснийг “худалдахаас бусад хэлбэрээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтад доор дурдсан агуулгатай тайлбар нэмэх:

“Тайлбар:энэ заалт нохой салхилах зориулалтын талбайд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “нохой, муур төрснөөс хойш зургаагаас арван хоёр сарын дотор” гэснийг “нохой, мууранд” гэж, мөн зүйлийн 9.2.5 дахь заалтын “ялгадсыг” гэснийг “өтгөн ялгадсыг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 9.4 дэх хэсэг нэмэх:

“9.4.Энэ хуулийн 9.2.3-т заасан үүрэг Монголын үндэсний уугуул үүлдрийн нохойны асран хамгаалагчид хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн “Нохой, муурын нэгдсэн бүртгэл” гэсэн гарчгийг “Нохой, муурыг бүртгэлд хамруулах, бичил чип суулгах” гэж өөрчилж, 10.1, 10.2 дахь хэсгийн “сум,” гэснийг тус тус хасаж, 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Нохой, муурын хаягийн бүртгэл нь асран хамгаалагчийн байнга оршин суугаа газрын хаягаар, нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах байрын оршин байгаа газрын хаягаар тус тус тодорхойлогдоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.7, 10.8 дахь хэсэг нэмэх:

“10.7.Энэ хуулийн 40.1.4-т заасан нохой, муурын нэгдсэн бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журамд дараах асуудлыг тусгана:

- 10.7.1.бичил чип суулгасан нохой, муурын асран хамгаалагчийн бүртгэл;
- 10.7.2.нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын бүртгэл;
- 10.7.3.нохой, муурын асран хамгаалагчийн сургалт явуулах хуулийн этгээдийн бүртгэл;
- 10.7.4.алдагдсан нохой, муурын бүртгэл.

10.8.Баг, хорооны Засаг дарга, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь бичил чип унших төхөөрөмжтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5

Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Асран хамгаалагч энэ хуулийн 10.1.2, 10.2.1-д заасан үндэслэлээр” гэснийг, 11.2 дахь хэсгийн “Сум,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.2 дахь хэсэг нэмэх:

“11.2.Хот, сууринаас бусад газарт нохой, муурын асран хамгаалагчаар бүртгүүлэхэд энэ хуулийн 11.1.3 дахь заалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням техникийн саатал гарч байгаа тул гар өргөж санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсгийн “сум, дүүргийн” гэснийг “нутаг дэвсгэр хариуцсан” гэж өөрчилж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “эрх бүхий этгээдэд” гэсний дараах “гэрийн тэжээвэр амьтныг” гэснийг хасаж, мөн зүйлийн 14.4 дэх хэсгийн “тухайн амьтныг” гэсний дараа “олох,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15, 16 дугаар зүйлийг нэгтгэн 15 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

15.1.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан ашгийн төлөө хуулийн этгээд эрхэлнэ.

15.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 41.1.2-т заасны дагуу нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгоно.

15.3.Энэ хуулийн 15.2-т заасан зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлийг тодорхой зааж бичгээр хариу өгнө.

15.4.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

15.4.1.зөвшөөрөл хүссэн өргөдөл;

15.4.2.энэ хуулийн 21.1.1-д заасан шаардлага хангасан нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны хэмжээ, нөхцөл байдлыг харуулсан гэрэл зураг, хаягийн нотлох баримт;

15.4.3.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар;

15.4.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

15.4.5.үржүүлэх нохой, муурын төрөл, үүлдэр, хүйс, тоо толгой, чипний дугаарын мэдээлэл.

15.5.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны нөхцөл байдалтай биечлэн танилцах эрхтэй.

15.6.Энэ хуулийн 41.1.5-д заасан нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх журамд дараах зүйлийг тусгана:

15.6.1.нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээлэл;

15.6.2.нохой, муурын үүлдэр;

15.6.3.нохой, муурын үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны эрүүл ахуйн шаардлага.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын “энэ хуулийн 16.4-т заасны дагуу ирүүлсэн зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргасан” гэснийг “энэ хуулийн 15.4-т заасны дагуу ирүүлсэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “асран хамгаалагчийн үүргийг” гэснийг “үүргийг асран хамгаалагчийн нэгэн адил” гэж өөрчилж, мөн зүйлийн 21.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.5.хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллаас 200 метрийн дотор нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулахгүй байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 23.2 дахь хэсэг нэмэх:

“23.2.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дуусгавар болсон тохиолдолд зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд нохой, муур үржүүлэх үйл ажиллагааг нэн даруй зогсоож, хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй нохой, муурыг иргэн, эсхүл энэ хуульд заасан зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24, 25 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “Нохой, муурыг төрснөөс хойш 45 хоногийн” гэснийг “Нохой, муурын үр төлийг 60 хоногийн” гэж өөрчилж, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.2.Нохой, муур үржүүлэгч нохой, муурын үр төлийг төрснөөс хойш гурван тун урьдчилан сэргийлэх тарилга болон туулгалтад хамруулсны дараа бусдад шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27 дахь хэсгийг энэ зүйлийн 27.1 дэх хэсгийн тайлбар болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.4 дэх хэсэг нэмэх:

“27.4.Энэ хуулийн 41.1.6-д заасан эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэхэд дагаж мөрдөх журамд дараах зүйлийг тусгана:

27.4.1.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээлэл;

27.4.2.түр байрлуулан асрамжлах газрын хөтлөх бүртгэл;

27.4.3.түр байрлуулан асрамжлах газар гэрийн тэжээвэр амьтан хүлээн авах, шилжүүлэх талаарх мэдээлэл.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “энэ хуулийн 17.1-17.4-т” гэснийг “энэ хуульд” гэж, мөн зүйлийн 29.3.1 дэх заалтын “энэ хуулийн 28.2-т заасны дагуу ирүүлсэн” гэснийг “эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 29.4 дэх хэсэг нэмэх:

“29.4.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа явуулах орон байрны нөхцөл байдалтай биечлэн танилцах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “асран хамгаалагчийн үүргийг” гэснийг “үүргийг асран хамгаалагчийн нэгэн адил” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.3.Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллаас 400 метрийн дотор эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37, 38 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтын “тухайлан тусгаж хэрэгжүүлэх,” гэснийг “тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавих,” гэж, 40.1.3 дахь заалтын “боловсруулах.” гэснийг “батлах,” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 40.1.4 дэх заалт нэмэх:

“40.1.4.Нохой, муурын бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга болон Цагдаагийн байгууллагын саналыг авч батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар найруулгын засвартайгаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41 дүгээр зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

41.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэрийн тэжээвэр амьтны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

41.1.1.нохой, муурын нэгдсэн бүртгэл хөтлөх, бүртгэлийн систем хөгжүүлэх;

41.1.2.нохой, муур үржүүлэх болон эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хугацааг сунгах;

41.1.3.нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын нэгдсэн бүртгэл хөтлөх;

41.1.4.нохой, муур үржүүлэх болон эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа энэ хуульд заасан шаардлага, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

41.1.5.нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах, түүний биелэлтийг хангуулах;

41.1.6.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах, түүний биелэлтийг хангуулах;

41.1.7.нохой, муурын асран хамгаалагчийн сургалт зохион байгуулах хуулийн этгээдийг бүртгэх;

41.1.8.нохой, муурыг түр байрлуулан асрамжлах газрын эрүүл ахуйн хөтөлбөрийг бүртгэж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

41.1.9.гэрийн тэжээвэр амьтны тухай хууль тогтоомжийг сурталчлах, гэрийн тэжээвэр амьтантай холбоотой иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх ажлыг тасралтгүй явуулах.

41.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 20.2, 31.2-т заасан мэдээллийг нийтэд ил тод мэдээнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “бүртгэл хөтлөх,” гэсний дараа “бичил чип унших төхөөрөмжөөр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “хууль тогтоомжийн” гэснийг “хууль тогтоомжийг сурталчлах,” гэж, 44.1.2 дахь заалтын “бүртгэл хөтлөх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах” гэснийг “үржлийг хязгаарлах, бичил чип суулгах ажлыг зохион байгуулах.” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 44.1.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.2.1 дэх заалтын “харгис хэрцгийгээр” гэснийг хасаж, 47.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.2.3.эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах, гэрийн тэжээвэр амьтан нь эдгэшгүй өвчин, гэмтэлтэй, орчин тойрондоо аюултайгаас бусад тохиолдолд унтуулга хийх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсгийн “шагнал” гэсний өмнө “сугалаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 52.2 дахь хэсэг нэмэх:

“52.2.Энэ хуулийн 12.4 дэх хэсгийг Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг хэрэглэх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хугацаанаас хойш мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.1.7 “энэ хуульд заасан журмын дагуу” гэснийг “энэ хуульд заасны дагуу”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “зүйлийн 18.1-т заасан эхний” гэснийг “хуулийн 18.1-т заасан бүртгэлийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.12 дахь заалт нэмэх:

“3.1.12.Удмын бичиг гэж цэвэр үүлдрийн нохойны дэлхийн байгууллагын албан ёсны гишүүн байгууллагаас олгодог уг амьтны гарал үүсэл, эцэг эх, төрсөн огноо, хүйс, үүлдэр зэргийг заасан бичиг баримт.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.4.6 дахь заалт нэмэх:

“15.4.6. нохойны хувьд цэвэр үүлдрийн тодорхойлох удмын бичиг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Нэг.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Нохой, эсхүл мууранд “гэснийг “Гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч, түр харагчийн нохой, мууранд” гэж өөрчилж, “бусад” гэсний дараах “гэрийн тэжээвэр амьтны

асран хамгаалагч, түр харагчийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “нэг нохой, эсхүл мууранд” гэснийг “нохой, муур тус бүрд бичил” гэж өөрчилж, мөн зүйлийн 11 дэх хэсгийн “шагнал” гэсний өмнө “сугалаа,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дугаар зүйлийн “5.1.55” гэснийг “5.1.57” гэж, “17 дугаар зүйлд” гэснийг “14 дүгээр зүйлд” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 21 дүгээр зүйлийн “21.1.38” гэснийг “21.1.48” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.10 дахь” гэснийг “6.44 дэх” гэж, “7.17” гэснийг “6.15” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “бүртгэж эрхэлнэ.” гэснийг “бүртгэж эхэлнэ.” гэж өөрчлөх, төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.4-т заасны дагуу нохой, муурын бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журмыг энэхүү хууль хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дотор баталж, нохой, муурын бүртгэлийн системийг нэг жилийн дотор хөгжүүлж, ашиглалтад оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан” гэснийг “Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай 9 дүгээр зүйл нэмэх:

“9 дүгээр зүйл.Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль хүчин төгөлдөр мөрдөхөөс өмнө үржил хязгаарлах мэс ажилбар хийлгээгүй найм болон түүнээс дээш настай нохой, муурын асран хамгаалагчид Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 05 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим, 11 цаг 57 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 52,6 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүдийн сонгогдсон тойрог, нэрээр танилцуулна. Ингээд Батсүхийн Саранчимэг гишүүн эмнэлгийн чөлөөтэй байгаа. Цогт-Очирын Анандбазар 4 дүгээр тойрог орон нутгийн томилолттой. Тилеуханы Аубакир 2 дугаар тойрог орон нутагт томилолттой. Жадамбын Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог ирсэн. Жигжидийн Батжаргал 14 дүгээр тойрог ирсэн. Буланы Бейсен 2 дугаар тойрог чөлөөтэй. Хаянгаагийн Болорчулуун 7 дугаар тойрог ирж байна. Гочоогийн Ганболд 10 дугаар тойрог ирсэн. Наянтайн Ганибал 12 дугаар тойрог ирсэн. Гонгорын Дамдинням 19 дүгээр тойрог ирсэн. Цагаанхүүгийн Идэрбат 18 дугаар тойрог ирсэн. Гөмпилдоогийн Мөнхцэцэг 6 дугаар тойрог орон нутагт ажилтай. Нанзадын Наранбаатар 11 дүгээр тойрог ирсэн. Дамдинсүрэнгийн Өнөрболор гадаадад томилолттой. Ганзоригийн Тэмүүлэн 1 дүгээр тойрог ирсэн. Цэвэгдоржийн Туваан 14 дүгээр тойрог ирсэн. Одонгийн Цогтгэрэл 15 дугаар тойрог ирж байна.

Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн 8 дугаар тойрог ирсэн байна.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээр асуудал. Гэрийн тээврийн амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын нарын гишүүд 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

2. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газар 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

3. Чиглэл өгөх тухай хуулийн Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Мөн саяын танилцуулсан Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр өргөн барьсан нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг санал дүгнэлтээ мөн Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу. Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Дарга аа, хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулах саналтай байна. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг манай ажлын хэсгийн ахлагч Цогтбаатар гишүүн хийхээр төлөвлөгдчихсөн байж байгаа. Тэгээд Цогтбаатар гишүүн ирж байгаа

юм байна. Тэгээд би ажлын хэсгийн сүүлийн хуралдаанд сууж амжаагүй байгаа учраас энэ танилцуулгыг танилцуулах боломжгүй болчихоод байна л даа. Тэгээд дарааллыг нь өөрчилж өгөөч гэж.

Ж.Бат-Эрдэнэ: Хэлэлцэх асуудлын талаар өөр санал байхгүй. Тэгвэл дарааллыг өөрчлөөд хэлэлцэх асуудлаа ингээд баталчихъя. 2 дугаар асуудлаас явчихъя.

Хэлэлцэх асуудалдаа оръё. 2 дугаар асуудал. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /Засгийн газар 2023 оны 10 сарын 31-ний өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэх. Энэ асуудлыг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Саналтай гишүүд алга. 2 дугаар асуудалтай холбоотой асуудал дээр Туваан гишүүн, Ганибал гишүүн. Ганибал гишүүнээр тасаллаа. Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гээд хууль манай Байнгын хороогоор орж ирж байна. Тэгээд энэ газартай холбоотой асуудал чинь ингээд хамгийн чухал, хүмүүсийн хамгийн суурь бүх юм газар дээр байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хуулиуд маань ингээд л нэг тийм энд тэнд хавсарга байдлаар Төсвийн тухай хууль дагаад ч өргөн баригдчихсан байж байна. Гишүүд ч өргөн барьчихсан явж байна. Бэлчээрийн тухай хууль дээр ч гээд ингээд бэлчээр чинь өөрөө газар дээр л байгаа шүү дээ. Тийм ээ. Ингээд одоо дахиад энэ нийслэл хотын хуулийг дагаад Нийслэл хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах гээд энэ асуудал

дээр ингээд ороод ирж байна. Тэгээд гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль дээр ч гээд ингээд маш олон газруудад ингээд нэг тийм хавсарга байдлаар ингээд яваад байна. Энийг ер нь хэдүүлээ яах ёстой юм. Ингээд энэ байдлаар нь ингээд нэгдмэл биш байдлаар Байнгын хороод дээр юм уу, эс үгүй бол гишүүд санаачлаад ингээд сэглээд явчих юм уу, эс үгүй бол энэ хуулиудаа бүгдийг нь тэр санаачилсан гишүүд нь энэ орж ирж байгаа байдлаар нь нэгтгээд хэлэлцэх ёстой юм уу. Би бол газрын асуудал дээр тийм хавсарга байдлаар, сэглэсэн байдлаар ингэж хандмааргүй санагдаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр манай Байнгын хорооноос ямар зарчим баримталж энийг өнөөдөр яг энэ Нийслэлийн хуулийг дагуулж оруулж ирж байгаа юм бэ. Ярьсан, тохиролцсон, хэлэлцсэн ийм асуудал байна уу гэдэг асуулт байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийг танилцуулъя. Борхүүгийн Дэлгэрсайхан Монгол Улсын Дэлгэрсайхан сайд ирээгүй байна. Пүрэвжавын Сайнзориг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч, Дорждэмбэрэлийн Цолмон Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах, Жамбалжавын Бямбадулам Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Жаргалсайханы Ичинноров Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга, Насанбатын Мөнхбаяр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газар чөлөөлөх хэлтсийн дарга, Ганбатын Ганхүү Нийслэлийн орон сууцын бодлогын газрын дарга, Чимэддоржийн Батзориг Нийслэл Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжгийн захирал, Доржготовын Хан-Уул Хот байгуулалтын хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, Д.Энхтуяа Хууль, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга, Дангаагийн Авирмэд Улаанбаатар хотын гэр

хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч, Маньбазарын Говьсайхан Нийслэлийн Орон сууцны корпорацын гүйцэтгэх захирал.

Саяынхтай холбоотой бас нэг тайлбар хийх хэрэгтэй болж байна. Энэ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолд Газрын багц хуулийн төсөл, түүнд нийцүүлэн Ашигт малтмалын тухай, Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон хамт холбогдох бусад хуулийн төслүүдийг боловсруулан 2023 оны 12 сарын 31-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн гарц газарт даалгасан.

Тэгэхээр Туваан гишүүний саяын асуусан асуулт бол ер нь 2023 оны 12 сарын 31-ний дотор Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу Газрын багц хууль орж ирэх ёстой. Одоо бид нар энэ хуулиа үзээд явчихдаг. Цаана нь 2 ч 3 ч хууль байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хуулиудаа ингээд сэглээд сэглээд явчих юм уу гэсэн нэг ийм л асуулт байна л даа. Хэн хариулах вэ. 2 номер.

П.Сайнзориг: Туваан гишүүний асуултад хариулъя. Ер нь бол нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуультай холбогдуулан л тодорхой газрын хуулийн нэмэлт, өөрчлөлт байгаа. Түүнээс биш яг нийт Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйлчлэх хуулийн зохицуулалт орж ирээгүй.

Яг Улаанбаатар хотын газрын харилцаатай үүсэж байгаа онцлог энэ асуудлуудыг нь цаг алдах боломжгүй байгаа учраас бас зэрэгцүүлэн орж ирсэн. Өөрөөр хэлэх юм бол орон сууцжуулах болон замын хөдөлгөөний түгжрэлийг бас бууруулахтай

холбоотойгоор дэд бүтцийн бүтээн байгуулалт дээр газрыг харилцан тохиролцож чөлөөлөх асуудал. Ямар үед нь албадан чөлөөлөх вэ, нөхөн олговрын хэмжээ, ямар дэс дараа зарчмаар явах вэ гэдэг асуудлууд одоо аль ч хуулиар зохицуулалтгүй байгаа учраас энэ асуудлууд нэлээн тийм хүндрэл бэрхшээлтэй буюу ингээд цаг хугацаа алдсан ийм байдалтай байж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бас цаг цаг алдалгүй зохицуулах үүднээс орж ирсэн. Ер нь бол энэ Газрын хуулийг бас эргэж харж шинэчлэх ёстой гэдэг бодлого бол Улсын Их Хурлаас баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бол тусчихсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд орсон. Нэг удаа Засгийн газар бас багц байдлаар нь өргөн барьсан боловч Барилга, хот байгуулалтын сайдаас Засгийн газраар дамжуулан бас түр татан авсан байгаа. Уг асуудал нэгдсэн байдлаар 12 сарын 31-ний дотор өргөн барина гэсэн ийм чиглэлийг ч бас сая төсөв батлагдах үеэр хийж өгсөн байна. Тэгэхээр мэдээж энэ хуулийг өргөн барина. Хэлэлцэх эсэх асуудал батлагдах цаг хугацааны хувьд бас Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал учраас яг тэр хуулийг хүлээгээд энэ асуудлыг явах юм бол Улаанбаатарын түгжрэл, дэд бүтцийн бүтээн байгуулалт, гэр хорооллыг орон сууцжуулах нийтийн эрх ашгийн төлөө зарим шийдвэр гаргах харилцаанууд удааширах, шийдэгдэхгүй хүлээлтийн байлдалтай л болчих гээд байгаа юм. Тэгэхээр энэ удаадаа ямар ч байсан яваад нэгдсэн байдлаараа Газрын хууль багц хуулиараа орж ирэх юм бол одоо ч гэсэн хэлэлцээд явж байгаа асуудал маань тусгагдаж орж ирэх ийм зохицуулалт, логик дэс дарааллаар явах болов уу гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Тэгээд яах вэ, энэ нийслэлтэй холбоотой асуудал гээд л орж ирдэг л дээ. Тэгээд би болохоор

яагаад цогцоор нь гэж яриад байгаа гэхээр Монгол Улсын газар нутаг чинь энэ хил бол тэлэхгүй, дотогшоо хумихгүй. Тэгээд энэ дотор чинь маш олон давхардлууд үүсдэг. Ойн сангийн газар байна, уул уурхайн лицензүүд байна, тариан талбай байна, бэлчээр байна тэгээд дээрээс нь энэ засаг захиргааны нэгжүүдийн асуудал хүртэл байгаа. Тэгээд би юу хэлж байна гэхээр одоо ингээд л дагаад л нийслэлтэй холбоотой л гэж байна. Тэгээд л Богд хан уулын хил хязгаарын асуудал, дээрээс нь нийслэл хотыг тойрч байгаа манай Төв аймагт л гэхэд миний мэдэж байгаагаар 6-7 сумтай газар нутгийн маргаан байгаа байхгүй юу. Шийдэх боломжгүй, гаргалгаагүй гээд. Тэгээд энийг зохицуулсан, үнэхээр нийслэл гэдэг малгайтай л орж ирж байгаа юм бол энэ асуудлуудыг яаж тооцоолж.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Туваан гишүүний асуултад нэмж хариулъя. Таны хэлж байгаа үнэн. Тэгэхдээ ер нь Улаанбаатар хотын бас хаашаа тэлж хөгжих вэ, ер нь цаашидаа бас яг Төв аймагтайгаа бүх талаар интеграцид орж ирж л хөгжих юм байна лээ. Тэгэхээр энэ дээр бас үүсэж байгаа нэг асуудал бол газрын асуудал, газрын хилийн цэсийн асуудал байгаа. Ер нь бол зөвхөн Төв аймаг, Улаанбаатар гэлтгүй бас бусад аймгуудад сум доторх маргаан болоод аймаг хоорондын маргаанууд одоо хүртэл шийдэх механизм маш хүнд. Өөрөөр хэлэх юм бол тухайн шатын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зөвшөөрсөн гэдэг асуудал байхаар ерөөсөө шийдвэр гаргах процесс байхгүй. Тэгэхээр нэгэнт Монгол Улсад төрийн байгууллага нэгдмэл учраас уг асуудлыг Газрын хууль дээр бол өмнө нь баригдсан байсан Газрын ерөнхий хууль дээр маш тодорхой заачихсан байж байгаа. Тэгэхээр энэ асуудлууд бас одоо яг таны хэлж байгаачлан 12 сарын 31-ний дотор

Засгийн газраас өргөн баригдах хууль дээр цогц байдлаар орж ирэх байх. Бид хэд бол энэ Төв аймагтаа үүсэж байгаа маргаан хийгээд энэ Богд уулын Дархан цаазат газартай холбоотой бүх асуудлуудыг судалсан. Байгаль орчны яам Улаанбаатар хотоос хилийн цэсийн маргаанаа бол урьдчилсан байдлаар.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Дахиад нэмж хариулъя. 2 дугаар микрофон ажлын хэсэг.

П.Сайнзориг: 200 гаруй нэгж талбарыг бас Байгаль орчны яамнаас газрын эрхийг нь цуцалж, хүчингүй болгож, эргээд энийг нь нийслэл Улаанбаатар хот газар ашиглах эрхийг нь өгөх үү, үгүй юү гэдэг бас ийм асуудлууд жоохон хууль зүйн талаасаа маргаантай байгаа юм байна лээ. Энэ хилийн цэсийн асуудлаас. Тэгэхээр энэ замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах орон сууцжуулах хуулийг дагаад бас Засгийн газарт чиглэл өгөх Улсын Их Хурлын тогтоолын төсөл орж ирсэн. Энэ тогтоолын төсөл дээр 1 дэх заалт дээр Богдхаан Дархан цаазат газрын хилийн заагийн хэмжээг бууруулахгүйгээр хилийн цэст өөрчлөлт оруулах асуудлыг судлан шийдвэрлэх, уг нутаг дэвсгэрт үүссэн суурьшлын бүсийг нийслэл Улаанбаатар хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулах гээд бас Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газарт чиглэл болгоод маш богино хугацаанд бас энийг шийдье гэж байгаа юм. Тэгэхээр бас яг энэ хууль хуулийг бас дагуулаад ороод ирэхээр бас нэлээн өргөн хүрээний асуудал байгаа учраас бид хэд бас энэ хуулиараа чиглэл аваад, богино хугацаанд энэ асуудлыг ер нь бас засаг дээрээ болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам цаашидаа ярих юм бол Төв аймагтайгаа зөвшилцсөн бас уг асуудлаа шийдье гэж байгаа. Тэгэхээр энд хотын үйлчилгээг үзүүлэх зайлигүй шаардлага гараад байдаг. Нутаг дэвсгэр нь тусгай хамгаалалттай газар нутаг байдаг, дээр

нь үл хөдлөх хөрөнгүүд нь бүртгэлгүй байдаг. Татвар хураамж авах уу, үгүй юу, хог, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэг тийшээ хүргэх үү, үгүй юу гээд маш олон тулгамдсан асуудлууд эргээд энэ газар нутгийн эрх зүйн байдлаасаа шалтгаалаад үүсчихсэн байж байгаа юм байна лээ. Тэгээд энийг бас Газрын багц хууль болон Байгаль орчны яам дээр явж байгаа Тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан цогц байдлаар нь шийднэ гэсэн ийм байдалтайгаар эхний ээлжид бид хэд харж байгаа юм аа.

Ж.Бат-Эрдэнэ: Ганибал гишүүн.

Н.Ганибал: Одоо энэ нийслэл гэдэг чинь Засгийн газар л даа. Засгийн газар маань ингээд 2 янзын хууль оруулж ирээд, сая төсөв дагуулаад бас нэг хууль оруулж ирсэн Газрын тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулахаар. Тэгээд эргээд ингээд нийслэлийнхэнтэй хамтраад бас нэг хууль оруулаад ирсэн. Ингээд нэг ийм хоорондоо авцалдахгүй, хэн дуртай нь өөрийнхөө хүссэнээр энэ хуулиудыг өөрчилдөг энэ байдал хэрээс хэтэрлээ. Үнэхээр хэрээс хэтэрлээ. Магадгүй манай энэ Хууль зүйн яамныхан маань сая Засгийн газрын оруулж ирсэн тэр төсөв дагасан Газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бас оруулж ирсэн байх. Тэгээд эргээд тэрнээсээ өөр бүгдээрээ нийслэл рүү шилжчихээд, нийслэл дээрээс бас эргээд ийм хууль өргөн бариад оруулаад ирлээ. Тэгээд энд тэнд хуулиудыг ингэж завхруулдаг ийм Хууль зүйн яамныхан маань энд тэнд очоод ингээд нэг ийм хууль өргөн барьдаг. Ер нь аж ахуйн ажилд очсоноо та бүхэн маань ер нь мэдэж байгаа юу. Тэгээд зөвхөн нэг хууль өөрчилснөөр бүх асуудлыг шийддэг байвал бас болж л байна л даа. Олон ч хуулийг бид нар энэ өнгөрсөн 8 жилийн хугацаанд өөрчиллөө. Байдал нэг ч дээрдсэнгүй. Улам дордоод байх юм. Тэгээд энэ дээр ингээд өргөн барьсан хууль чинь та хэдийн тэр Засгийн газарт байхдаа, Хууль зүйн

яаманд байхдаа өргөн барьсан хуультай чинь зөрчилдөөд байна шүү дээ. Энэ чинь бүх эрхээ Ерөнхий сайд өөрийнхөө мэдэлд авна гэсэн. Одоо та нар болохоор энэ дээр эргээд нийслэлд бас маргааныг шийдвэрлэдэг, мөн бусдад газар эзэмшүүлэхгүй, ашиглуулахгүй тийм хориг тавьдаг гэсэн ийм заалтууд оруулаад ирчихсэн. Энэ 2 чинь тэгээд цаашаа явах юм уу. Ер нь тэгээд нийслэлийн энэ сайхан нэртэй. Хүмүүсийн амьдрал дээр хамгийн их болохгүй байгаа юмыг өөрчилнө л гэж байгаа болохоос яг энэ хуулиар чинь тийм их олон өөрчлөлтүүд орох юм уу. 26 үндсэн хуулиуд дээрээ, органик хуулиуд дээр өөрчлөлт орж ирнэ гээд байгаа юм. Тэгээд энэ дээр бусдын эрх ашгийг хорих тал дээр, цаашилаад газар чөлөөлөх асуудал дээр 65 хувь нь зөвшөөрч байвал шууд бусдыг нь хүчээр 35 хувьд дээр нь хүч хэрэглэх байдлаар ч гэдэг юм уу, захиргааны шүүхээр шийдүүлээд явна гэсэн ийм заалтууд хүртэл яваад байгаа шүү дээ.

Тэгээд миний энэ бодож байгаагаар энэ Газрын тухай хууль дээр зүгээр ийм хууль дагуулаад өөрчлөлт хийгээд яваад байх боломж уг нь баймааргүй юм. Тэгээд энд тэнд энэ Газрын тухай хуулийг сэглээд сэглээд яваад байдаг. Тэгээд энэ асуудал дээр ер нь сая тодорхой Их Хурлын чиглэл өгчхөөд байхад эргээд л ингээд дагуулаад ороод ирсэн. Заавал энэ олон хуулиудыг яаралтайгаар шийдүүлэх гэж ингэж дайраад байгаагийн мөн чанар бас цаана нь бас ойлгогдохгүй л байгаад байгаа юм л даа. Тэгэхээр сая Туваан гишүүний хэлдэг асуултууд чинь зүгээр яг детальный асуугаад байна шүү дээ. Бид нар ийм замбараагүй байдалтайгаар энэ үндсэн газрын эрх зүй гэдэг чинь маш чухал асуудал шүү дээ. Газар гэдэг бол тусгаар тогтнол, тухайн нутаг дэвсгэр дээр, газар дээр амьдарч байгаа хүмүүсийн аюулгүй байдал өмч эзэмших байдал гээд бүхий л асуудлуудыг хөндсөн энэ чухал хуулиа өнөөдөр ингээд л эргээд бас нэг хууль дагуулаад л оруулаад л ирж

байгаа юм л даа. Эд нарыг ер нь ингээж ийм байдлаар асуулаа. Одоо тэгээд 12 сарын 31-нд шинэ хууль өргөн баригдахаар энэ асуудлууд чинь эргээд л хөндөгдөөд явна шүү дээ. Эргээд хөндөгдөнө. Эргээд хэлэлцэгдэнэ. Тэгэхээр энийг заавал ингээж яаруулаад өөрчлөх шаардлага байгаа юм уу. Асуулт байна. Энийг ингээд өнөө маргаашгүй баталлаа гэхэд 12 сарын 31-ээс өмнө энэ хуулийг ашиглаад ямар асуудлуудыг та нар шийдэх юм бэ.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Ганибал гишүүний асуултад харилъя. Таны хэлж байгаа энэ болгоомжлол, шүүмжлэлийг бид хэд ойлгож байна. Хүлээж авна. Бас тодорхой хэмжээнд уялдаагүй явж байгаа юм шиг харагдаж байгаа зүйл байна. Энэ хуулийг өргөн барихад улсын хууль маань бас батлагдаагүй байсан.

2 дугаарт. Яг уг асуудалтай холбоотойгоор Засгийн газар багц хуулиа татан авчихсан учраас нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд бас тулгамдаж байгаа газартай холбоотой асуудлыг шийдэх хууль, эрх зүйн орчныг тодотгохоос өөр аргагүй байгаа юм. Төсвийн хуулийг дагаж орж ирсэн Газрын хуулийн нэмэлт, өөрчлөлт маань Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд байсан агентлаг буюу чиг үүргийг Ерөнхий сайдын эрх хэмжээнд аваачиж байгаа. Зөрчилдөх зүйл байхгүй байгаа. Энэ хуулиар нийслэлд үүсэж байгаа газартай холбоотой маргааныг бүгдийг нь шүүх гэж бас иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг чирэгдүүлэхгүйгээр маргаан таслах зөвлөлтэй болгоё. Хотын 6 дүүргийн хэмжээнд газар олголт гэдэг зүйлүүдийг цэгцтэй явахгүй бол өнөөдрийн хотын тулгамдсан асуудал гэдэг бол хот төлөвлөлт, газар олголттой холбоотой авлига ашиг сонирхлын асуудал байна. Нийслэлийн Засаг дарга энэ эрхийг шилжүүлж

авахдаа дөрөвхөн үндэслэлээр газрыг шинээр олгоё гэж байгаа юм. Дахин төлөвлөлттэй холбоотойгоор, газрыг дүйцүүлэн өөр байришил дээр газрыг олгохоор бол, шүүхийн шийдвэрээр гэдэг юм уу, маргаан эцэслэн шийдэгдсэн гэдэг юм уу, тодорхой тохиолдлуудад олгоно. Бид хэд тэгэхдээ энэ асуудлуудыг байнгын ийм байдалтай байлгаж байгаа биш. Эхний ээлжид уг асуудлуудыг цэгцлэхгүйгээр Улаанбаатар хотын бүтээн байгуулалт болон хот төлөвлөлтийн асуудлыг шийдэж чадахгүй юм байна гэж үзэж байгаа. Мэдээж яг энэ Улаанбаатар хотын ажил бол аж ахуйн ажил, өдөр тутмын ийм ажлууд байгаа боловч хууль, эрх зүйн талаасаа шийдвэр гаргах орон зайгаа тодорхой болгож процессын хэмжээнүүдийг шийдэж авахгүй бол бүх зүйлүүдийг хуульгүй хүч түрээд яваад байж болохгүй байгаа. Тэгэхээр энэ хот төлөвлөлтийн дахин асуудал бол Бат-Үүл даргын үеэс эхэлсэн боловч гаргасан шийдвэрүүд нь Цэц дээр унадаг ч юм уу, ингээд энэ асуудлууд бүдгэрч байгаа учраас бид хэд энэ алдааг бас давтахыг хүсээгүй юм. Энд бас хэн нэг иргэний эрх ашиг бүү хохироосой гэж бодож байгаа учраас хууль тогтоогчоос эрхээ авч бас тодорхой журмуудыг гаргах энд нь хэн хэнийх нь буюу эрх ашгуудын балансыг тэнцвэртэйгээр зохицуулъя гэсэн үүднээс энэ асуудлыг зохицуулж байгаа. Энэ багц хуулийг бас хүлээхгүйгээр яаравчилсан асуудал юу вэ гэхээр жишээ нь Сэлбэ, Баянхошуу дэд төвийндэд бүтцийн бүтээн байгуулалт бол бэлэн болчихоод байна. Энэ бол жишээ нь Эй Ди Би-ийн санхүүжилтээр хийгдсэн буюу 100 сая ам.долларын бүтээн байгуулалтын ажил хийгдсэн боловч энэ дэд бүтцийн ашиглалт дөнгөж 18 хувьтай 20 хүрэхгүй хувьтай байгаа. Энэ зээлийн тоолуур маань гүйгээд байгаа боловч газар чөлөөлөлт гэдэг юм уу эргээд хот төлөвлөлтийн энэ тодорхой асуудлуудаасаа болоод энэ бүтээн байгуулалтууд явахгүй байгаа юм. Тэгэхээр бид хэд энэ орчны бохирдол болон түгжрэл, утааны асуудлуудыг гэр

хорооллыг л эцсийн дүндээ орон сууцжуулж шийдье ээ. Түүнээс биш зуух, түлш ч гэдэг юм уу маш олон зүйлээр үзсэн. Энэ зардлууд л явсаар л байгаа. Тэгэхээр энэ асуудлуудыг бас цэгцэлж байж иргэдийнхээ аятай тухтай орчинд болоод нийслэл Улаанбаатар хотод тулгамдсан энэ асуудлуудыг шийдээд явна гэсэн ийм зүйлүүдийг л энэ хуулиараа оруулж ирж байгаа.

Ер нь зүгээр Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу газрыг нөхөн төлбөртэйгөөр авах эрх байгаа. Тэгэхдээ аль хуулиар вэ гэдэг нь нарийвчилсан зохицуулалт байхгүй учраас л газрыг тодорхой хэмжээнд чөлөөлөх энэ харилцаа дээр бас ямар зарчим барих вэ, ямар хувь хэмжээнд нь тухайн төсөл хэрэгжүүлэгч талбарын өрхүүдийн айлуудын, газар өмчилж байгаа, эзэмшиж байгаа, ашиглаж байгаа хүмүүсийг зөвшөөрвөл энэ харилцаа явах юм бэ гэдэг асуудал байгаа. Тэгэхээр юу гэдэг юм, байшин барилгыг нь шууд нураах гээд байгаа зүйл биш, тодорхой хэмжээний жишиг үнэлгээнд заасны дагуу нөхөн төлбөртэйгөөр энэ газрыг чөлөөлнө гэсэн ийм харилцаа явж байгаа. Тэгээд бид хэд энэ хуулиудыг батлуулж чадвал, бас энэ Сэлбэ, Баянхошуу төвийнхөө бүтээн байгуулалтыг ирэх жилээс эхлүүлэх, өвлийн сардаа бас айлуудтайгаа зөвшилцөх ийм процессыг эхлүүлэх ийм төлөвлөгөөтэй явж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлье ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Ганибал гишүүн тодруулъя.

Н.Ганибал: Ер нь тэгээд энэ концепц чинь буруу байгаа юм. Та хэд ингээд шууд газрыг чөлөөлөөд маш олон давхар байшингууд бариад нэгж талбай дээр амьдрах хүний тоог нь ихэсгээд байхаар чинь эргээд л тэнд түгжрэл бий болно шүү дээ. Тэгээд энэ үндсэн ярьж байгаа асуудлын чинь гаргалгаа нь өөрөө буруу байхад бид нар энэ хуулийг оруулж ирээд батлах нь ч бас зарчмын хувьд буруу л даа.

Ер нь түгжирнэ гэдэг чинь нэгж талбай дээрх хүний тоо их болоод, тэр нь багтахгүй болохоороо л түгжрээд байгаа шүү дээ. Тэрнээс бол энийг яаж тэлэх юм, яаж тэр урсгалыг нь зөв болгох юм. Тэр тойрог замуудын асуудлууд дээр өнөөдөр ярихгүй байгаад байгаа байхгүй юу. Хамгийн гол нь 7 буудлаас нисэх ороход хотын төвөөр дайрдаггүй болгодог л энэ асуудлыг л бид нар шийдэх ёстой. Ингэж чадаж байж бид нар энэ түгжрэлийн асуудлыг шийднэ үү гэхээс хойноосоо урагшаа явж байгаа, баруунаасаа зүүн тийшээ явж байгаа бүх машин хотын төвөөрөө дайрдаг.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: 2 дугаар микрофон. Ажлын хэсэг.

П.Сайнзориг: Яг Ганибал гишүүний асууж байгаа асуулттай холбоотойгоор л энэ газар чөлөөлөх хуулиуд яригдах юм. Энэ тойрог замын бүтээн байгуулалтыг бас ирэх жилүүдээс эхлүүлэхээр ТЭЗҮ, зураг төслөө хийгээд явж байгаа. Эхлүүлэхээр явж байна. Яг энэ тойрог замын бүтээн байгуулалтын асуудал дээр 2700 нэгж талбарыг чөлөөлөх асуудал яригдана. Метроны асуудал өнөөдөр Засгийн газар дээр ТЭЗҮ-ээ хийлгэх гэдэг чиглэл хөндлөн чиглэлд яригдаж байна. Энэ метрог байгуулахад хүртэл газар чөлөөлөлтийн асуудал явагдаж байгаа юм. Тэгэхээр бид энэ газар чөлөөлөлтийг гэдэг “А” иргэнээс “Б” иргэн рүү шилжүүлэх тухай биш. “А” гэдэг иргэний газрыг нийтийн эрх ашгийн төлөө нийт Улаанбаатарчуудад болон Монголчуудад хамаатай дэд бүтцийг байгуулах чиглэлд нь чөлөөлөх, тэгэхдээ үүнийгээ хүний эрх, эрх ашгийн балансыг хангаж нөхөн төлбөртэйгөөр чөлөөлөх асуудал байгаа юм. Тодорхой нэгж талбар дээр чөлөөлж бас өндөршилтийн хувьд тийм өндөргүй орон сууцуудыг зөв төлөвт нягтаршуулж чадвал тэнд бас түгжрэл энэ тэр бас гарахгүй ээ. Яг энэ магадгүй Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтыг.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ганибал гишүүн. Үгүй ээ, үгүй. Туваан гишүүн энэ асуудал дээрээ асуусан шүү дээ. Ер нь асуудлаа 2 дахь асуудал гэж танилцуулаад явсан.

Н.Ганибал: Газар чөлөөлнө гэдэг чинь хуулиар гэхээсээ илүүтэй одоо байгаа эрх зүйн хувьд чөлөөлөх боломж байдаг. Энийг та нар тэр Сүхбаатар аймгаас сонгогдсон Батсуурь гишүүнээс очоод нэг сайн туршилага судалчих. Хүн болгонтой уулздаг юм байна лээ. Уулзаж учирч, ярилцаж, хэлэлцэж, өөрсдийнхөө бодлогыг тайлбарлаж чадвал тэнд газар чөлөөлөгдөнө. Бусад боломжууд бий болдог. Тэрнээс өнөөдөр хууль гаргаснаараа бүх газрууд чинь чөлөөлөгдөнө гэсэн ойлголт бас байхгүй ээ. Тэгээд тэр дээр аж ахуйн ажил гэдэг чинь иргэдтэйгээ уулзаж, өөрсдийнхөө бодлогыг танилцуулаад, эхлээд зургаа гарга. Тэгээгүй байж байж юун өнөөдөр шууд хууль гаргачхаад, дараа нь зураг төсөв яриад байх юм. Хийх ажлаа эхлээд төлөвлөхөөд, тэрэнтэйгээ уялдуулаад энэ хууль эрх зүйгээ болго л доо. Тэгэхгүй ингээд нэг юу юугүй 7 хоног ажил авчхаад 10 дахь хоног дээр нь хууль өөрчилнө гээд. Энэ чинь явж байгаа зам чинь буруу байна л гэж хэлээд байгаа байхгүй юу даа.

Ж.Бат-Эрдэнэ: Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Энэ нийслэл Улаанбаатар хотын түгжрэлтэй холбоотой асуудлыг бид нар шийдээ, энэ асуудлыг зохицуулаа гэж Улаанбаатар хотын Засаг даргаа солиод, Түгжрэлийн сайдаа солиод, эрчимтэй, яаралтай хууль, эрх зүйн орчны өөрчлөлтийг оруулж ир гээд энэ хүмүүсийг томилоод явуулсан. Монгол Ардын намы бүлгийн шийдвэр, даргын шийдвэр, Ерөнхий сайдын шийдвэр ч гарсан. Бид нар Их Хурал дээрээ ч ярьсан. Бид нар энэ хүмүүсийг хурдтай ажиллаад оруулаад ир гэж явуулсан. Ингээд оруулаад ирж байгаа хуулийг нь бид нар дэмжээд явуулах ёстой. Улаанбаатарын

түгжрэлийн асуудлыг бид нар хуулиар шийднэ. Ардчилал, хүний эрх бид нар яриад байгаа боловч энэ улс чинь өөрөө энэ Улаанбаатар хотдоо хямралын байдал руу орчихсон байгааг бүгдээрээ харж байгаа. Тэгээд яг энэ шийдлийнх нь хуулийг нь оруулаад ирэхээр ингэж болохгүй, тэгж болохгүй. Тийшээ ч нэг, ийшээ ч нэг гээд шалтаг тоочоод хойшлуулбал энэ хүмүүсийг буруутгаад байх эрх бид нар гэрт байхгүй болно шүү дээ найзууд аа. Чадна гэж байгаа дээр нь хийж өгөөд л явуулчихмаар байна шүү дээ. Үгүй ээ, тэгээд бид нар хийгээд л явуулахаас өөр аргагүй л байхгүй юу. Тэгээд гарыг нь хүлээтэй, хөл нь тушаатай, тэгээд араас нь зодоод байвал наад хүмүүс чинь хаашаа явах юм. Тэгээд дараагийнхаа Засаг даргыг нь огцуулна, дараагийнхаа сайдыг огцуулна. Юу шийдэгдэх юм, юу шийдэгдэхгүй шүү дээ. Тэгээд батлаад явуулах нь зөв. Онцгой хямралын нөхцөл байдалд орчихсон байгаа бол онцгой хямралын үед хэрэгжүүлдэг менежментийг энэ хүмүүсийг хий гээд л явуулж байгаа шүү дээ. Тэгээд батлаад өгөх л хэрэгтэй. Тэгээд би бол тийм бодолтой байна.

Тэгэхдээ та нар бас энэ гишүүдийн ярьж байгаа, анхааруулж байгаа энэ аргачлал юмнуудыг нь бас тусгах ёстой байх шүү. 2 асуулт байна.

Түүрүүн Туваан гишүүн асуугаад байсан. Энэ хууль зөвхөн Улаанбаатар хотод үйлчлээд байх юм байхгүй байх. Хууль бол Монгол Улс даяар л үйлчилнэ. Магадгүй та нар энийг бас энэ улсын чанартай хотууд, аймаг нийслэлүүд дээр, аймаг дүүргүүд дээр үүснэ гэж тооцож энэ хуулиа хийж өгвөл их зүгээр байна. Ялангуяа Хууль зүйн яаманд ажиллаж байсан хүмүүс Улаанбаатар хотод, энэ захиргаа дээр очиж ажилласан учраас. Би яагаад энэ асуудлыг ярьж байгаа вэ гэхээр 1 дүгээрт, Дархан, Сэлэнгэ 2 дээр бас асуудал үүсээд байдаг юм ялгаагүй яг Төв аймагт үүсдэг шиг. Дархан-Уул аймаг гэж байна. Хараа голыг гараад

Сэлэнгэ аймгийн газар нутаг дээр Ширээ нуруу буюу Дархан-Уул аймгийн 2 дугаар баг, 3 дугаар багийн иргэд амьдарч байна. Сэлэнгэ аймгийн сум дангаараа Дархан хотдоо ямар ч зөвшилцөл байхгүй. Дархан-Уул аймагт ямар ч зөвшилцөл байхгүй 5, 6 мянган айлын газар олгогдсон. Тэнд нь бид нар ямар ч дэд бүтэц хийх боломжгүй. Тэнд Дарханы иргэд амьдраад байдаг, сургууль байхгүй, цэцэрлэг байхгүй, зам байхгүй, гэрэл байхгүй, ямар ч төлөвлөлт байхгүй. Тэгэхээр энэ асуудлыг хуулиар шийдэж болох уу. Миний ойлгож байгаагаар нийслэл Улаанбаатар хотын захирагч бас аймгийн дарга нар энэ газрын зохион байгуулалтыг хийх өөрчлөлт энд орж ирж байна гэж ойлгож байгаа. Зөв үү. 1 дүгээр асуудал. Тэгэх юм бол 2 аймаг энийгээ төлөвлөлттэй зохион байгуулаад явдаг энэ зарчим руугаа ормоор байна.

2 дугаар асуудал. Энэ хууль зайлиггүй батлагдах ёстой, зөв зохион байгуулалт хийгдэх ёстой нэг шалтгаан бол энэ авлигал хороолол байгаа шүү. Авлигал хорооллын газрыг 2008 онд дүүрэг өгсөн. Хан-Уул дүүрэг өгсөн. Дараа нь нийслэлийн захирамж болгож өөрчилсөн. Ингээд өнөөдрийн энэ бантан жонхуу болчихсон. Тэгээд авлигалаа толгой дээрээ залчихсан ийм байдалтай байгаа. Шүүх нь болохоор байгаа хуулиа мөрдөөд, цуцлаад байдаг. Улаанбаатар хотын захиргаа нь зориуд ялагдах захирамж гаргаж өгөөд шүүх дээр очоод ялагдчихаад байдаг ийм л нөхцөлтэй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлтөөр энэ заваан юмаа цэгцэлж чадах уу та нар. Оруулсан уу Сайнзориг дарга аа. Ийм 2 асуултад хариулаач.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, орон сууцжуулах тухай хуулийг дагаж орж ирж байгаа хуулиуд маань үндсэндээ гол төлөв нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн зохицуулалтууд байгаа. Таны асууж

байгаа Газрын хуулийн энэ асуудал бол нийслэлийн асуудлаа эхлээд шийдье. Засгийн газраас Газрын багц хуулийг 12 сардаа багтааж нэгдсэн байдлаар оруулж ирэх асуудал дээр улсын хэмжээнд үйлчлэх тэр газар чөлөөлөлтийн асуудлууд орж ирнэ. Бидний хувьд бол газар чөлөөлөлтийн болоод тэр өмнөх өргөн баригдаад татагдсан газрын багцын хууль дээр манай яамны бүрэлдэхүүн ажилласан. Анх концепц дээр нь бүгд дээр нь суулцаж Эй Ди Би-ийн хийж байсан тэр загвар дүрэм журмуудыг бүгдийг нь судалж байж бас хийлцсэн. Энэ хүрээндээ ямар ч байсан Улаанбаатар хотын асуудлыг дагуулж орж ирээд нийт Монгол Улсад үйлчилчих хууль хийж болохгүй юм байна гэж үзээд, бид нар одоогийн зүгээр энэ асуудлаа бол зөвхөн Улаанбаатарынхаа асуудлыгтай холбоотойгоор зохицуулалтыг нь оруулж ирсэн. Тэгэхээр энийг бас Засгийн газар дээр бас том ажлын хэсэг гарчихсан явж байгаа юм байна лээ. Даваасүрэн сайдад бас Засгийн газар дээрээс бас тодорхой чиглэлүүд өгөгдсөн. Энийг 12 сард Төсвийн тухай хууль батлагдахад бас Улсын Их Хурлын тогтоолоор Засгийн газарт үүрэг өгөгдсөн байна. Энэ үүсэж байгаа асуудлыг тэр асуудлын хүрээнд бас цогц байдлаар нь шийдэж оруулж ирнэ гэдэг зүйлийг хэлье.

Ер нь газрын асуудал бол Монгол Улсад нэлээн замбараагүй байгаа. 2002 оны газар өмчлөх хуулиасаа эхлээд бид хэд дэд бүтэцгүй газруудыг өмчилж эхэлснээс болоод өнөөдөр энэ өмчлөгдсөн хэсгүүд дээр дэд бүтцийг татах асуудлуудын маргаан яг ингээд татагдаж байгаа. Нөгөө газрыг нь иргэддээ эдийн засгийн эргэлтэд оруулж өгье гэхээр тодорхой бүр эрх ашгуудыг хөндөхөөс өөр аргагүй болчихож байгаа юм. Тэгэхээр бид хэд цаашидаа бас Газрын хуулийн концепцоор дэд бүтэц цацчихсан газрыг өмчлөх асуудлыг ул суурьтай ярихаас өөр арга байхгүй. Засгийн газраас өргөн баригдсан тэр

хууль дээр бол ийм концепцоор явж байгаа.

Дээрээс нь авлига хорооллын асуудал яг энэ хуультай, хуульгүйгээр бид нар бол шийднэ. Энэ эхнээсээ голын голдирол дээр баригдсан Шунхлай трейдинг компанийн шатахуун түгээх станцыг бас өнгөрсөн амралтын өдөрт хүлээж авч газрыг чөлөөлсөн. Одоо Эс аутлайтын газрыг чөлөөлөх асуудал явагдаж байна. Дотор нь байгаа бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг шилжүүлэх асуудал хувийн хэвшил маань шийдвэл харилцан тохиролцоод бас газрыг чөлөөлнө гэж үзэж байгаа. Авлига хорооллын буюу голын голдирол дээр баригдсан 2 блок барилгыг буулгах шийдвэр бол гаргасан. Энэ захиргааны хэрэг дээр бол тодорхой зүгээр хууль зөрчсөн байна. Засаг даргын захирамж бол хууль зөрчсөн байна гэж гараагүй. Зүгээр түдгэлзүүлчихсэн байгаа. Хэрэг маргаан хянан шийдвэрлэх хүртэл. Тэгэхээр бид хэд бас нөгөө талынхаа эрх ашгийг хангаад Захиргааны хэргийн шүүх дээр бас хариуцагчаар татагдана. Өөрсдийн тайлбар үндэслэлүүдээ гаргаад ингээд явж байна. Энийг бас тодорхой түвшинд шүүхийн маргаан эцэслэгдэж шийдэгдэнгүүт бас энэ голын голдиролд орсон 2 блокийг буулгах ажиллагааг эхлүүлнэ. Бас буулгах асуудал дээр бас тендер зарлагдсан байж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дамдинням гишүүн дахин тодруулъя.

Г.Дамдинням: Тэгээд Сайнзориг дарга аа, 2 асуудал байна.

1 дүгээрт энэ авлигал хороололтой холбоотой хаа нэг газар энэ Улаанбаатар хотын газрын наймаа завхрал зогсох ёстой байхгүй юу. Би бол энэ дээр сүүлийн 2 жил ярьж байна. Хаа нэг газар энэ хулгай луйвар зогсох ёстой. Тийм учраас энийг нэхнэ шүү. Нэхнэ шүү. Дуустал чинь нэхнэ. Та нар энийгээ дуусгаарай. Тэгээд хамгийн гол дуусгах ёстой юм бол энэ хувийн хэвшил гэхээсээ

илүүтэй тэр үед энэ газрын зөвшөөрлүүдийг өгсөн захирамжийг өөрчилсөн хүмүүсийг хууль хяналтын байгууллагад нийслэлээс өгч байгаа юу. Тэр төрийн албан хаагчид хамгийн гол буруутай шүү. Тэр хүмүүстэй ярих ёстой.

2 дугаарт. Таны энэ оруулж ирсэн хууль чинь Засгийн газрын орж ирж байгаа хууль дээр дахиад засагдаад явчих вий дээ. Тийм учраас нийтээр нь бодоод энэ өөрчлөлтөө хийгээрэй л гэж хүсье. Тэгэхгүй бол энэ болохгүй шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 2 дугаар микрофон. Тодорхой асуулт асуулаа шүү дээ. Хариуцлага яаж тооцох юм.

П.Сайнзориг: Хариуцлагын асуудал яригдаж байгаа. Одоогийн байдлаар газрын албанаас 9 хүн шалгагдаж байгаа. Ажиллаж байгаа 9 хүн бас ямар нэгэн байдлаар ашиг сонирхол авлигын хэргээр Авлигатай тэмцэх газар дээр шалгаж байна. Манай өмчийн газар дээр шалгагдаж байна. Ер нь бол нийслэлийн өмчийн асуудал бүртгэл энэ тэр нэлээн тийм бодит байдал бол замбараагүй явж байгаа юм байна лээ. Бид энэ асуудлыг цэгцэлнэ ээ. Ер нь зүгээр нийслэл бас 2,5 их наядын өртэй, 1,7 их наядын төсөл хөтөлбөр хэрэгжилт эхэлсэн боловч дуусгаагүй, бүгд бас тодорхой хэмжээний маргаантай. Уг асуудал нь газрын асуудлаас бас болж байгаа юмнууд байна. Тэгэхээр ер нь зүгээр нийслэл дээрх энэ өмчийн харилцаа газар дагасан энэ юмнуудыг бас нэлээн цэгцэлье гэж шинэ Засаг дарга концесс дэвшүүлсэн. Түрүүчээсээ эхлээд бид нар бол тодорхой шийдвэрээ гаргаад Авлигатай тэмцэх газарт шалгуулахаар өгч байна. Тэгэхээр энэ дээр бол бас таны хэлж байгаа санал комментыг бид нар бас анхааралдаа авч ажиллая. Тэгээд яг хэдийгээр энэ дээр.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүний микрофоныг нээе. Дамдинням гишүүн асуулт асууна.

Г.Дамдинням: Тэгээд Сайнзориг дарга аа, бид нар энэ газрын хууль ярьж байна. Тэгээд Улаанбаатар хотын газрын наймааны эсрэг л хууль шүү дээ ер нь бол. Тэгэхээр авлигал хороололтой холбоотой, тэгээд энэ хувийн хэвшил рүү дайраад байна гэж өөр өнцгөөр хандаад байгаа хүмүүст би бол зориуд бас энэ Байнгын хорооны хуралдааны индэр дээрээс шууд хариуцлагатай хэлье. Номер нэг асуудал бол энэ газрын наймаа хийсэн төрийн албан тушаалтнууд шүү. Энэ хүмүүстэй бид нар хариуцлага тооцох ёстой. Тэгэхээр нийслэл дээр байсан том багагүй Нийслэлийн Засаг дарга байсан ч хамаагүй шүү дээ. Бүгдийг нь та нар тэр Авигатай тэмцэх газар, хууль хяналтын байгууллагад нь өгч шалгуулаарай.

2 дугаарт энэ хүмүүст нөлөөлсөн тэр хувийн хэвшлийнхэнд нь хариуцлагыг нь тооцуулаарай. Ийм л асуудлыг яриад байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Хуульд өөрчлөлт оруулаад явах нь зөв байх. Нийслэл Улаанбаатар хотыг бас ажлаа хийх бололцоо, боломжоор бид нар хангаж өгөх хэрэгтэй. Энэ утааны асуудал, түгжрэлийн асуудал ярихаараа л бид нар нийслэл Улаанбаатар хотын Засаг дарга руу л бүгд дайрдаг шүү дээ. Тэгээд 1 хуулийн төсөл ороод ирэхэд нь хууль зөрчиж байна, бөөнд нь оруулж ирэх ёстой гэдэг ийм байдлаар бас хандаж болохгүй байх гэж бодож байна. Тэгээд яах ёстой юм гэхээр энэ гэр хорооллоо яаралтай дахин төлөвлөх хэрэгтэй байж байна. Хуучин байшингуудаа бид нар яаралтай буулгаад, дахин төлөвлөлт хийх хэрэгтэй байж байна. Энэ өвлийн улиралд бид нар тэр зураг төслөө хийдэг бол зураг

төслөө хийгээд, 4 сар ч гэдэг юм уу, 5 сард энэ том бүтээн байгуулалтаа эхлүүлэх хэрэгтэй байна. Энэ тойрог замынхаа асуудлыг, метроны асуудлыг, энэ барилга байгууламжаа барих асуудал гээд яаралтай л эхлүүлэх хэрэгтэй байна л даа. Тийм учраас энэ хуулийг бол дэмжиж байгаа. Ер нь цаашидаа бол Нийслэлийн Засаг даргын бас эрх хэмжээг бас тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх, нийслэл ч гэхгүйгээр ерөөсөө л бүх шатын Засаг даргын эрх хэмжээг бас нэмэгдүүлэх, бие дааж өөрөө үйл ажиллагаагаа явуулах, газар чөлөөлөх, худалдаж авах бүх эрх зүйн орчныг нь л нээж өгөх хэрэгтэй. Тэгээд яг цагаа тулахад хэн хариуцлага хүлээдэг гэхээр ерөөсөө л Засаг дарга, засаг даргын Тамгын газар, түүний харьяа агентлагууд л хүлээдэг шүү дээ. Тийм учраас бид нар хуульд нь өөрчлөлт оруулаад, энэ хэдийг маань бас ажлаа хийх бололцоо боломжоор хангаж өгөх хэрэгтэй гэж бодож байна.

2 дахь асуудал бол ямар асуудал байна гэхээр тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын асуудал байгаа юм. Тэгээд энэ дээр та бүхэн минь нэлээн сайн анхаараач. Ялангуяа юу гэдэг юм Нийслэлийн Засаг даргын мэдлийн газар дээр Байгаль орчны яам газар олгочихсон байдаг. Байгаль орчны яамны Тусгай хамгаалалттай газар нутаг дээр Нийслэлийн Засаг дарга газар олгочихсон байдаг. Энэ хилийн цэсийн асуудлаа бас нэг баталгаажуулаад, энэ асуудлаа нэг гаргахгүй бол ер нь бас цаашидаа бол нэлээн хүндрэл учирна шүү. Одоо бид нар та бүхэн мэдэж байга. Энэ яармагийн асуудал байж байна. Яармагийн байшингууд маань үндсэндээ хот төлөвлөлт байхгүй, зам харгуй байхгүй, дэд бүтэц нь яаж явж байгаа нь одорхойгүй гээд. Тэгээд сургууль, цэцэрлэг байхгүй гээд. Тэгэхээр цаашидаа бол бид нар энэ хилийн цэсийг өөрчлөд нийслэл Улаанбаатар хот Тусгай хамгаалалттай газар нутгаа өөрсдөө олгоод, өөрсдөө энэ хот төлөвлөлтөө

хийгээд явах нь маш зөв байгаа юм. Тэгэхгүй ингээд Байгаль орчны яам дээр хамаг юм оччихдог, Байгаль орчны яам бол газар олгодог болохоос хотын төлөвлөлтийн асуудлыг хийдэггүй. Тэгээд энэ чинь бас түгжрэлийн бас нэг том шалтгаан байгаа шүү. Тийм учраас Тусгай хамгаалалттай газар нутгийнхаа тухай хуулийг бас яаралтай оруулж ирэх, ялангуяа юу гэдэг юм Хөдөө аж ахуй, байгаль орчны байнгын хороо дээрээс 2 ч удаа ажлын хэсэг гарсан шүү дээ. 2022 оны 8 сарын 1-нд Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийг баталгаажуулаач ээ гээд засаг руу чиглэл өгсөн. 2023 оны 1 сарын 17-нд миний бие бас ахлаад энэ нийслэл Улаанбаатар хотод болон Байгаль орчны яамны энэ тусгай хамгаалалттай газрын хилийн цэсийг дахиж нарийвчилж баталгаажуулаач ээ гэдэг ийм асуудал тавьсан. Энэ ер нь ямар шатдаа явж байгаа юм. Байгаль орчны яамтайгаа хэл амаа олголцож, ойлголцож байгаа юм уу. Ингэж байж цаашидаа бол юу гэдэг юм, Яармагийн болон бусад тусгай хамгаалалттай газрын хотын ерөнхий төлөвлөгөө энэ түгжрэлийн асуудал ч басдавхар шийдэгдээд явах ийм бололцоо боломж байж байгаа юм. Энэ дээр 1 тайлбар өгөөдхөөч. Тусгай хамгаалалттай газар нутаг дээр.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь яг таны хэлж байгаа бас энэ томоохон бүтээн байгуулалтын зураг төслийн ажил болон цаашидаа бас яг холбогдох төсвийг орон нутгийн төсөвт суулгаж, бэлтгэл үе шатуудыг яаралтай бас энэ цаг хугацааны хувьд хангах. Мэдээж барилгын сезон эхлэхтэй зэрэгцүүлээд зарим ажлыг эхлүүлэх энэ ажлыг бид нар үе шаттай төлөвлөөд явж байна.

1 дүгээрт бол нийслэлийн ирэх жилийн төсөв бол тэр чигтээ камержуулалт болон газар чөлөөлөлт,

эргээд зам болон гэр хорооллын дотор холбоос замуудын бүтээн байгуулалт гэсэн үндсэн ажлууд руу ингээд төвлөрч ажиллахаар бид нар бас төсвүүдээ бас боож бэлтгэхээр ажиллаж байгаа. Яг газар дээр нь газрын асуудал гэдэг бол бүх юмны асуудал болчхоод байгаа гэдэгтэй бол тантай санал нэг байна. Тэгээд нийслэл Улаанбаатар хотын бас онцлог буюу эргээд Төв аймгийн газар хүрээлүүлсэн нутаг дэвсгэртэйгээс гадна Тусгай хамгаалалттай газар нутаг буюу Байгаль орчны яамтай үеийн үед бас маргаантай. Хот төлөвлөлт болон үнийгээ дагасан бас нэлээн олон асуудлууд явагдаж ирж байгаа. Энэ Богд Хаан дархан цаазат газрууд дээр бол отог нэртэй орон сууцын хорооллууд бол боссон нь үнэн. Бүр энэ бол бодит факт. Тэгэхээр үүний үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээнүүд гардаггүй тодорхой хэмжээний хот нийтийн аж ахуйн үйлчилгээнүүд үзүүлэх шаардлагатай байдаг. Тэндэх сургууль, цэцэрлэг барих уу, үгүй юү. Хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлж бас цаашидаа асуудал яг хандах уу, үгүй юү гэдэг асуудал ч гэсэн хууль, эрх зүйн хувьд тодорхойгүй ингээд явж байгаа. Яг таны ахалсан энэ ажлын хэсгийн хүрээнд Байгаль орчны яамтай хотын яг Богд Хан уулын Дархан цаазат газар буюу Яармагийн хэсгээр газрын хилийн цэсийн маргаанаа зөвтгөсөн асуудал бол байгаа. Уг асуудал бол аль аль талаасаа хилийн цэсээ хүлээн зөвшөөрч дүгнэлтүүд гарсан боловч яг хэрэгжилтийн асуудал дээр очоод зогссон байж байгаа. Өөрөөр хэлэх юм бол Байгаль орчны яам бид нар бол энэ газар 200 нэгж талбарын газрын эрхийг, газар ашиглах эрхийг цуцлаач ээ гэдэг хүсэлтээ тавьсан. Байгаль орчны яам дээр байгаа нөгөө газар ашиглах эрхтэй этгээдүүд маань Байгаль орчны яамд ямар хүсэлт тавьж байна гэхээр нийслэл яг энэ бид нарын газрын эрхийг яг олгох юм уу гэдэг асуудал байгаа. Тэгэхээр бид хэд нийслэл өөрөө эргээд газрыг зөвхөн дуудлага худалдаа болон яг хуульд заасан үндэслэлийн дагуу олгодог. Үүнээсээ

болоод Байгаль орчны яамнаас бас газрын ашиглах эрхийг цуцлаагүй одоо хүртэл бас хилийн цэсийн маргаан нэгдсэн санал дүгнэлтэд Яармаг хавиар хүрсэн боловч яг бодит байдал дээр бол шийдвэрлэгдээгүй байгаа. Тэгэхээр уг асуудлыг бас Газрын багц хууль болон үүнтэй уялдуулж Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга бас явж байгаа. Намайг бол яг би яаманд ажиллаж байхад үзэл баримтлал нь баталчихсан. Яамдуудаас санал авах энэ тэр ажиллагаа явж байгаа. Тэгэхээр уг асуудлынхаа хүрээнд бас шилжилтийн үеийн зохицуулалт энэ тэрийг нь бас тодорхой хийж нэг мөр шийдэхгүй бол тодорхой хэмжээний ийм өмчийн маргаанууд бас гарах ийм эрсдэлүүд бол байгаа. Эргээд бол нийслэл бол энэ дээр Байгаль орчны яамнаас шилжингүүт шууд газрын эрхийг баталгаажуулж өгөх бол хууль эрх зүйн боломжгүй. Баталгаажуулаад өгөх юм бол харин бид бас өөрсдөө хууль зөрчсөн үйлдэл рүү ингээд орох ийм асуудал байгаа юм. Тэгэхээр энэ асуудлын бодит байдал иймэрхүү л явцтай байна.

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн дахин тодруулъя.

Т.Энхтүвшин: Нэгэнт олгогдчихсон, баригдчихсан барилга байгууламжийг бол ер нь тусгай хамгаалалттай газар нутаг дээр голдуу л юу гэдэг юм орон сууц л барьсан байна лээ шүү дээ. Тийм учраас энийг бол тусгай хамгаалалтаас яаралтай гаргах хэрэгтэй л гэж бодож байна. Тэгээд энэ асуудал дээрээ та хэд маань Байгаль орчны яамтайгаа нэг учир зүйгээ олоорой. Байгаль орчны яам бол юу гэдэг юм хяналтаа тавьж чадаагүй, 2 дугаарт ерөнхий төлөвлөгөө болон хот төлөвлөлт хийгдээгүй маш олон аж ахуйн нэгж барилга бариад, ингээд гэрчилгээгээ олгоогүй байж байгаа. Тэгээд үүнээс болоод юу гэдэг юм тэнд орсон иргэд маань хохироод байна шүү дээ. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээгээ авч чадаагүй. Нийслэл Улаанбаатар хот ч

гэсэн үл хөдлөх хөрөнгийнхөө татварыг авч чадаагүй. Бараг тооцоод үзэх юм бол жилдээ 20 гаруй тэрбум төгрөгийг үл хөдлөх хөрөнгийн татвараас авах ийм бололцоо боломжийг л алдаж байгаа шүү дээ. Тэгээд яам нийслэл 2-ын хооронд үүссэн маргаанаас болоод л ингээд.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ганболд гишүүн үг хэлье. Асуулт.

Г.Ганболд: Ер нь бол нийслэлийн оруулж ирж байгаа энэ хуулиудыг бас яаралтай дэмжье гэсэн ийм бодолтой байгаа. Энэ хууль дээр бол ерөөсөө дөрөвхөн асуудал байна.

1 дүгээрт нь Улаанбаатарын эдийн засгийн тусгай бүс тогтоох, тэлэх,

2 дугаарт нь энэ сервитүүд тогтоож, газрыг албадан чөлөөлөх,

3 дугаарт нь бол энэ газрын маргаан таслах зөвлөл байгуулах,

4 дүгээрт нь бол ерөөсөө энэ эдэл эдэлбэр газрыг Засгийн газар олгодог байсныг Нийслэлийн иргэдийн Хурал олгодог ийм л 4 ласуудал байна л даа. Тэгэхдээ хэрэгжихэд их төвөгтэй. Сервитүүд тогтооно. Нөхөн төлбөрөө яах вэ, нөхөн төлбөрийн асууда. Энэ хүмүүс Үндсэн хуулиар газар хувь хүний хөрөнгө өмч, Үндсэн хуулиараа бол өмчтэй байх ёстой. Шүүхэд хандана шүү дээ дахиад л. Энэ хууль гарлаа гээд дахиад л шүүх дээр шийдэгдэх гээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр бол яг та нар яаж хандаж харж байна. Энэ серветүүдийг би харахдаа шууд нийслэлээс үнэгүй авчихсан газар, эсвэл хэд дамжуулаад өндөр үнээр авчихсан хүмүүс дээр яг яаж тогтоох вэ. Энэ өөрөө 2, 3 өөр ойлголт байхгүй юу. Тэгэхээр энэ дээр яг та нар яг ямар бодлоготой байгаа вэ гэдгээ хэлээч.

Маргаан таслах зөвлөл ер нь заавал байх хэрэг байгаа юм уу. Энэ дээр чинь маргаан таслах зөвлөл дээр 1удаа 30 хоног, дахиад 30 хоног. 60 хоног маргаан таслах зөвлөлийн шийдвэр эцсийн шийдвэр биш шүү дээ. Дахиад л шүүх дээр очно. Тэгэхээр энэ чинь бас л нөгөө сунжруулах, бүр нөгөө хурдлах биш, сунжруулах дунд нь нэг алхам маргаан таслах зөвлөл гээд нэг байгууллага хийчхээж байгаа юм биш үү. Энэ дээр яг ямар бодолтой байгаа юм. Энэ маргаан таслах зөвлөл гэдэг юм яг үр дүнгээ өгөх үү. Дараа нь бүгдээрээ шүүх дээр очно. Тэгээд л эцсийн шийдвэр шүүхийн шийдвэр л болно шүү дээ. Тэгэхээр энэ хуулийг зарим нэг юм дээр бол бараг л дамжлага хийчихсэн юм шиг харагдаад байна. Тэгэхээр энэ эдэлбэр газрыг тогтоох чинь Засгийн газрын л эрх байсан л даа. Та нар нийслэлийн эдэлбэр газрыг тэлэх ямар ч боломжгүй. Иргэдийн хурал. Хэрэв тэлэх юм өөр аймгийн, өөр сумын эрх ашиг хөндөгдөнө. Тэр эрх ашиг хөндөгдсөн тохиолдолд багийн иргэдийн нийтийн хурлаар, сумын иргэдийн хурлаар, аймгийн иргэдийн хурлаар орж байж л энэ шийдвэр эцэслэгдэх байхгүй юу. Тэгэхээр зэрэг нийслэлийн эдийн засгийн чөлөөт бүс ч адилхан эдэлбэр газар ч адилхан. Та нар эдэлбэр газраа тэлнэ гээд Богд уул руу явъя гэхээр тусгай хамгаалалттай мөргөлдөнө. Тэр дахиад хуультай. Өөр сум руу орёе гэх юм бол дахиад л өөр хуультай зөрчилдөнө шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ зүйлүүд дээр ер нь Сайнзориг дарга яг ямар бодолтой байгаа юм. Жишээлэх юм бол энэ серветүүд дээрээ та нар байна шүү дээ. Жаахан тодорхой юм хийхгүй бол 48.3.6 Усны сан болон ойн сангийн газарт байгалийн дагалт баялаг ашиглах, аялах гэдэг нь юу гэж байгаа юм. Аялах газар гэдэг нь нийтийн тийм юм байх юм уу, аяллын газар байгуулна гээд хүний газар чөлөөлөөд явах юм бол энэ өөрөө утгагүй байхгүй юу. Тэгэхээр яг энэ түгжрэлтэйгээ холбогдуулж тойрог зам хийх гээд явж байхад газраа чөлөөлөхгүй байгаа хүмүүс юм уу, төмөр зам юм уу, яг ийм газруудаар тодорхой

зааж өгөхгүй бол хэт өргөн хүрээнд болоод тэгээд л юм л бол ерөөсөө хүний газрыг ингээд хүчээр чөлөөлнө гээд л ингээд л нэг асуудал ороод явах юм бол энэ төвөгтэй шүү.

Нөхөн төлбөрийн асуудлаа бас та нар энийг 2 салгаарай. Би түрүүн хэлсэн шүү дахиад. Шууд нийслэлээс үнэгүй авсан хүний газар 2, 3 дамжиж үнэтэй авсан газар 2-ыг бүүр эх сурвалжаар нь ялгаж үзэхгүй бол өчнөөн тэрбумаар авсан хүний газрыг авна гэвэл энэ өөрөө буруу асуудал болох байхгүй юу. Тэгэхээр энэ хуулийг хэдүүлээ гаргахдаа зөв. Гэхдээ гаргахдаа эргээд л очоод л нэг шүүх дээр ч юм уу очоод мөргөх юмыг бид нар баталлаа гээд үр дүн яг байна уу, үгүй юү гэдэг дээр та нэг тодорхой тайлбар хэлээд өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 2 дугаар микрофон. Өөрийгөө танилцуулаарай.

П.Сайнзориг: Сайнзориг Нийслэлийн Засаг даргын 1 дүгээр орлогч. Ганболд гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн тусгай бүс гээд энэ Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар 2021 онд орж ирсэн ойлголт байж байгаа. Энэ чөлөөт бүсээс арай өөр ойлголт. Энийг зөвхөн нийслэл Улаанбаатар хотын дагуул хот дээр байгуулахаар заасныг бид нар өргөжүүлж зөвхөн дагуул хотоор хязгаарлахгүйгээр өөрийнхөө нутаг дэвсгэр дээр байгуулж болъё, магадгүй бусад засаг захиргааны нэгжтэй бас харилцан тохиролцож байгуулж болох юм байна гэж үзэж байгаа. Тэгэхээр Улаанбаатар хотын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор магадгүй Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны партизаны чиглэл дээр бид нар эдийн засгийн тусгай бүс байгуулахаар ажиллаж байна. Энэ дээр бол тодорхой хэмжээний татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүд бол дэмжих ажлууд байх юм. Магадгүй яг хүлэмжийн аж ахуй болон эрчимжсэн мал аж ахуй,

тэндээ сүүн бүтээгдэхүүнээр нийслэлчүүдийг хангах ч гэдэг юм уу. Тэгэхээр энэ өөрөө зөв бид эхлүүлж чадах юм бол цаашидаа Төв аймгийн Батсүмбэртэй нийлүүлээд дагуул хот байгуулах эрх зүйн үндэс ч бас цаашидаа бүрдэх юм гэж үзэж байгаа юм. Ийм байдлаар бас эдийн засгийн энэ тусгай бүсийн асуудлуудыг байгуулах асуудлаа зөвхөн дагуул хот гэж хязгаарлалттай байдлыгаа бас чөлөөлж өгч байгаа. Нийтийн эдэлбэр газрын асуудал дээр нийтийн хэрэгцээний тусгай хэрэгцээний газрынхаа ангилалд л оруулж ирэх ийм асуудал байж байгаа. Энэ эдийн засгийн тусгай бүсийн газар болоод тодорхой ийм ангилалд нь оруулах үүдээс ингэж орж ирсэн. Серветүүдийн асуудал дээр би бас танд нэмэлт мэдээлэл өгье. Серветүүд гэхээр яг энэ хамгийн ойрхон гэх юм бол энүүгээр орц гарц буюу түргэний тэрэг, галын машин өнгөрөх орц гарц гаргамаар байна гэхээр манайхны одоо практик юу вэ гэхээр гол төлөв газраасаа хасалт хийлгэж дахиж хэмжээгээ бууруулж гэрчилгээгээ ав гэдэг. Тэгэхээр бид хэд тухайн иргэний эрхийг зөрчихгүйгээр таны яг олгосон хууль ёсны дагуу эзэмшиж байгаа, ашиглаж байгаа газраас чинь хэмжээг нь бууруулахгүй ээ. Бид нөхөн олговор буюу энүүгээр зам тавьсныхаа төлбөрийг төлөөд дээд тал дээр энэ айлуудын орц гарцыг гаргаж галын машин хүрэх тэр замыг тавих гэсэн юм гээд тухайн тэр иргэнд олгосон газрын эрхийг хөндөхгүйгээр бас тодорхой тохиролцож энэ байдлаар шийдье гэж байгаа юм. Тэгэхгүйгээр ингээд хасалт хийлгэ, 1 метр өг, 2 метр хасалт хийлгэ гээд ингээд зах замбараагүй ийм юмнууд явж байгаа юм.

2 дугаарт магадгүй нийтийн болон хувийн сервитүүд гэдэг ойлголт байгаа. Нийтийн сервитүүд дээр жишээ нь дүүжин тээвэр явуулахын тулд аймаар олон айлуудын газар чөлөөлөх гэхээс илүүтэйгээр тэр газрууд дээр явах тэр шонгуудыг тавих хэсэг дээр серветүүд тогтоогоод бид энэ дүүжин

тээвэр явахтай холбоотойгоор энэ шонг тавьсныхаа төлбөрийг танд ийм байдлаар төлье гээд газрын эрхийг нь багасгаж халдахгүйгээр тохиролцох энэ бололцоог сервитүүд дээр бас бий болгож нэлээн тийм өргөжүүлж энэ харилцааг явах гэж байгаа.

Маргаан таслах зөвлөл. Тэгэхээр ер нь зүгээр Татварын маргаан таслах зөвлөл ч гэдэг юм уу маш олон тийм мэргэжлийн этгээдүүд тухайн харилцааг шүүхийн шатад шийдэхээс өмнө явах юм бол иргэд, аж ахуйн нэгж байгууллага болгонд ийм зардал багатай цаг хугацаа хэмнэсэн ийм үйл ажиллагаа байж байгаа. Үнэхээр энэ асуудалтай санал нийлэхгүй гэвэл шүүх рүүгээ явж болно. Тэгэхээр бид хэд өнөөдөр бас Нийслэлийн Засаг даргын Тамгын газар дээр ирж байгаа нийт өргөдлийн дийлэнх нь яг газрын маргаантай холбоотой юм байна. Тэгэхээр энэ асуудлуудыг яг мэргэжлийн институт шийдэхгүй бол Засаг даргын Тамгын газрын Хуулийн хэлтсийн хүмүүс л шийдээд явахаар тодорхой хэмжээнд бас асуудлуудыг шийдсэн гэж үзэхэд хэцүү. Эргээд ийм зүйлүүд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээрээ бас тодорхой хэмжээний тал талын төлөөлөлтэй мэргэжлийн ийм цаг хугацаа хэмнэсэн зардал хэмнэсэн байдлаар үнэхээр Засаг даргын гаргасан шийдвэртэй гэдэг юм уу газрын эрхтэй холбоотой аж ахуйн нэгж байгууллагуудын хооронд үүссэн маргааныг урьдчилсан байдлаар шийдээд өгөх юм бол шүүх дээр ингэж сунжирдаг, зардал гаргаж чирэгдэлтэй явдаг энэ асуудлууд бас тодорхой хэмжээнд буурна гэж үзэж байгаа юм аа тэгээд. Энийг бас бусад маргаан шийдвэрлэх асуудлыг урьдчилсан байдлаар шийдвэрлэх механизмыг татварын маргаан таслах зүйлтэй адилхан ийм байдлаар санаа авч бас ингэж оруулж ирж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд ингээд асуудал ороод ирж байгаа юм. Мэдээж энэ нийслэл хотын түгжрэлийг бууруулах, орон сууцжуулах асуудлыг дэмжиж байгаа. Гэхдээ энэ харилцааг шийдэхийн тулд бусдын гэдэг юм уу залгаа амьдарч байгаа нэгжүүдийнхээ эрх ашиг руу дайраад байдаг юм байж таарахгүй л дээ. Эдийн засгийн тусгай бүс ч гэх шиг янз бүрийн юм яриад, тэрнийгээ шийдэхийн тулд бусдын нутаг дэвсгэрээс оруулж төлөвлөх гээд энэ тэр байдаг юм байж таарахгүй ээ. Ийм тусгай бүсүүд хийх гэж байгаа бол тэр тусгай хэрэгцээндээ авч Засгийн газрынхаа түвшинд шийдэх хэрэгтэй. Нэгжийнхээ түвшинд биш. Тийм учраас үүнийгээ их зөв бодож харж хийгээрэй. Ер нь бол энэ баахан болж бүтэхгүй байгаад байгаа юмнууд чинь төрийн байгууллагуудын ажлын уялдаа байгаагүйтэй л холбоотой шүү дээ. Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар энэ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар 2-ын хоорондын ажлын уялдаа, мэдээлэл, бодлогын нэгдмэл байдал алдагдсантай л холбоотой зүйл шүү дээ. Ер нь бол яг үнэнийг хэлэхэд. Байгаль орчны яам улсын тусгай хэрэгцээний газар нутагт тэр хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулах зориулалтаар газар олгочихоор зэрэг нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар нь байдаг юм уу эс үгүй бол Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь эскиз хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг нь батлахдаа орон сууцжуулалтын төлөвлөгөө батлаад өгчихөөр чинь энүүнийг чинь хууль бус гэж яаж хэлэх юм. Ерөөсөө бид нарын гол алдсан алдаа энд л байгаад байгаа шүү дээ. Наадхыг чинь бас нэлээн судалж үзсэн. Тийм учраас энэ мэдээллийнхээ нэгдмэл байдлыг хангах асуудлаа харин энэ хууль дотроо их тодорхой оруулж өгөх тухай асуудал байгаа юм.

2 дугаарт нийслэлийн гэдэг юм уу, газар зохион байгуулалтынхаа ерөнхий төлөвлөгөө, хотын ерөнхий

төлөвлөгөөндөө тодотгол хийх замаар л энэ асуудлуудыг шийднэ. Өөр бидэнд ямарваа нэгэн гаргалгаа байхгүй.

2 дугаарт та хэдийн яриад байгаа асуудлууд энэ хуульд яг тэр утга агуулгаараа ормоор байна. Үнэн. Тэр агаарын гэдэг юм уу, тийм тээврийн юм хийх гэж байгаа бол ганц шон айлын хаашаанд зоохдоо тэр айлыг газар чөлөөл гээд байдаггүй. Тэр шон зоосон газартаа ноогдох хөрөнгийнхөө асуудлаа тэр айлд нь төлөөд асуудлаа шийдээд явдаг энэ гаргалгаа юмнуудаа энэ хуульдаа өөрөөр уншигдахааргүй л оруулаад өгчих л дөө. Тэгж уншигдахгүй байгаад байна шүү дээ энэ чинь. Тодорхой хэмжээний асуудлыг нь нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлагын үүднээс асуудлыг зохицуулах гээд байгаа юм шиг ийм юм уншигдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг ийм хоёрдмол утгагүйгээр байж болдог тэр арга хэлбэрээр нь шийдэхээр л энэ дотроо л асуудлаа шийдэж оруулах талын л юм баймаар санагдаад байх юм. Тэгээд үүнийг чинь аль заалтаараа яг зохицуулагдаж ороод байгаа юм гэдэг асуудал чинь ихээхэн эргэлзээтэй, маргаантай ийм л зүйл байна шүү дээ. Үүнийгээ та хэд маань юу гэж ойлгож үзээд байгаа юм.

Дараагийн нэг асуудал нь тэр юу байгаад байгаа юм. Дагаж орж ирээд байгаа тэр тогтоолын төслийн асуудалд нь явж байгаа юм уу үгүй юу. 3 дахь асуудал юм уу. Ийм асуудлууд дээр нэг тодорхой тайлбар юмнуудыг нь авчихмаар байх юм. Юу гэж ойлгоцгоогоод байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Би бас мэдээллээ бас дутуу өгөөд таныг буруу ойлголт төрүүлчих шиг боллоо. Эндээ хүлцэл өчье. Эдийн засгийн тусгай бүсийг дагуул хот буюу зөвхөн дагуул хот дээр байгуулагдахаар байсан. Одоогийн байдлаар нийслэл Улаанбаатар хотын

харьяа дагуул хот байгуулагдсан гэдэг юм уу, тодорхой ишийдвэр гараагүй. Тийм учраас эдийн засгийн тусгай бүсийг жишээ нь өөрийнхөө нутаг дэвсгэр дээр нийслэл байгуулья гэж байгаа. Тэгээд магадгүй одоо бол Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Партизаны сангийн аж ахуйг түшиглэсэн байдлаар хүнс, хөдөө аж ахуйн тийм кластер байдалтай хөгжүүлж чадвал алсдаа магадгүй Батсүмбэр гэдэг юм уу байгалийн төрх тогтцын хувьд ижил төрөл буюу нийслэл Улаанбаатар хотын хүнсний хангамжийн аюулгүй байдлыг хангах, сургууль, цэцэрлэгийн хоолны хүртээмжийг сайжруулах чиглэлдээ энэ бүс нутаг бас зөв төлөвлөлттэй ажиллах юм байна гэж бид харж байгаа. Тэгэхгүйгээр энэ асуудлыг зуслангийн бүс болгоод алдчихаж бас болохгүй байгаад байгаа юм. Тэгэхээр бид хэд ийм байдлаар бас алсдаа харж байгаа. Тэгээд мэдээж Төв аймагтайгаа Улаанбаатар хот бол зайлигүй ойлголцож явах ёстой газар нутгаас нь авна, авахгүй гэдэг тухай биш эдийн засгийн хувьд харилцан ашигтай байдлаар тодорхой төслүүдийг хамтарч хэрэгжүүлэх энэ бололцоог нээх талаас байгаа. Ер нь эдийн засгийн тусгай бүс байгуулах асуудал Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын хуулиараа Засгийн газар ишийдвэрлэх юм. Энэ мэдээлэл дээр өгье.

Ер нь зүгээр энэ төрийн байгууллагуудын ажлын уялдаатай холбоотойгоор асуудлууд үүсэж байгаа гэдэгтэй би тантай санал нэг байна. Хуулийн асуудлаасаа ч болж байна, ажлын уялдаа ч байна. Энэ хуулийн тодорхойгүй орчин дээр энэ ажлын уялдаа бүүр нэмэгдчихээр хариуцах эзэнгүй, дундаа асуудлуудыг ишийддэг ийм л байдалтай байгаа. Газрын асуудал гэхгүй. Өнөөдөр Улаанбаатар хотын дэд бүтцийн асуудал дээр зарим газар дээрх болон газар доорх дэд бүтэц эцсийн өмчлөл нь нийслэлд зарим нь яамдуудад байгаа. Яамдууд дотроо бүр 5, 6 яамдуудын дунд. Тэгээд яг энийг дагасан зөвшөөрөл болохоороо бүгд эрх мэдлийн

төлөө булаацалддаг. Асуудлуудыг хариуцах maintenance хийж авч явах, хөрөнгө оруулалт хийх болохоор дундаа хаячихдаг ийм нөхцөл байдлууд бол нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд бол тулгамдсан асуудал байгаа. Тэгэхээр энэ ажлын уялдааг сайжруулах асуудлыг 1 дүгээрт хууль, эрх зүй, зохион байгуулалт, үйл ажиллагаагаа ил тод нээлттэй болгохоос эхлээд явж байгаа юм.

Ер нь зүгээр таны хэлж байгаа Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг бас энэ ондоо Засгийн газраас өргөн барихаар Барилга, хот байгуулалтын яам дээр ажлын хэсэг гарчихсан явж байна. Өмнө нь бол Засгийн газраа хэлэлцүүлэх гэж байгаад бас Барилга, хот байгуулалтын сайд түр хойшлуулсан байгаа. Бид энэ төлөвлөгөөгөө нэлээн тийм нарийвчлалтай үзэж, лон улсын экспертүүд бас авч ажиллуулах ийм байдалтайгаар төлөвлөөд явж байгаа. Тэгээд энэ ондоо багтааж Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө буюу 20/40 гэсэн ерөнхий төлөвлөгөөг Улсын Их Хуралд оруулж бас хэлэлцүүлэх ажлыг Засгийн газраас хийнэ ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Батжаргал гишүүн тодруулна.

Ж.Батжаргал: Энэ зэргэлдээ оршиж байгаа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд хамтарч хөгжлийнхөө асуудлыг бас хүнсний хангамж аюулгүй байдлаа ч гэдэг юм уу олон асуудлуудаа ишийдэж болно. Тэр нь Газрын хуулиар зохицуулагдахгүй. Тэр Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульдаа нэгжүүд хөгжлийнхөө төлөө хамтарч ажиллаж болох тэр эрх зүйн зохицуулалтыг нь л хийж өг. Газрын хуульд ороод ирчихээр бусдынхаа газар нутгаас тодорхой хэмжээний юм салгах гээд байгаа юм шиг ийм ойлголт бууж орж ирээд байгаа байхгүй юу. Үйл ажиллагааны хувьд л яригдах ёстой

болохоос биш газар нутгийнхаа хувьд яригдах зүйл биш ээ. Бусад нэгжээр өөрийнхөө хөгжлийн гэдэг юм уу, хэрэгцээт зүйлсээ хийлгэж болдог тэр дээр тогтвортой хамтарч ажиллаж чаддаг тэр рүү 2 талаасаа хөрөнгө юмаа.../минут дуусае/

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Хотын түгжрэлийг бууруулах, барилгажуулах гээд бас нэг цаг үеийн шинжтэй ийм анхдагч хуулийн төсөл орж ирж байна л даа. Тэгээд энэ хуулийн төслийг харахаар шийдэл гэж байгаа зүйлүүд нь үнэхээр харамсалтай. Яг ямар үр дүн гарах нь эргэлзээтэй. Тэгсэн мөртөө энэ хууль дээр ингээд тоймлоод харахаар 3, 4 зүйл байгаа юм. Би эхнээс нь хэлье л дээ.

1 дүгээрт нь газар чөлөөлнө гэдэг зүйл хуулийг болоод дагалдах хуулиудад орж ирж байгаа юм. Энэ нэг ийм иргэний өмчлөх эрхийг хэрхэн яаж хуульчилж булааж авах вэ гэдэг.

2 дугаарт нь газар олгох асуудлыг төвлөрүүлнэ. Засгийн газар шийднэ гэж байгаа юм. Нөгөө бид нарын яриад байдаг өөрөө удирдах ёс нутгийн онцлог олон зүйл ингээд төвлөрүүлж шийднэ ээ.

1 дүгээрт нь ингээд хувийн өмчид халдана, 2 дугаарт нь төвлөрүүлнэ.

3 дугаарт нь татвар нэмж болно. Татвар нэмнэ. Нөгөө бид нарын яриад байдаг татвар авч төр улам томорч төр улам хүчтэй болох юм байна.

4 дүгээрт нь энэ хуулийг дагаж орж ирсэн нэг зүйл нь нийслэл дээр шууд худалдан авалтуудыг зөвшөөрнө. Хуульчилна. Нөгөө яриад байдаг нүүрсний гэрээ, нөгөө яриад байдаг ногоон автобус чинь шууд худалдан авалтаас л үүдэлтэй шүү дээ. Тэгэхээр энэ орж орж ирж байгаа шийдэл гэх зүйлүүд нь хувийн өмчид халдах, төвлөрүүлэх, татвар

нэмэх, шууд хаалттай худалдан авалтуудыг дэмжих гэдэг. Хэрхэн яаж засаг төр өөртөө эрх авах вэ гэдэг хэдэн ийм гол заалтыг бусад заалтуудаар чимэглэхсэн нэг ийм л хууль л орж ирээд байна л даа. Яг агуулга нь бол. Үнэхээр та нар эдгээрээс өөр хотын эдийн засаг гэдэг зүйлийг урамиуулж, энэ харилцааг зохицуулах. Уг нь бол хүн амын төвлөрөл гэдэг чинь тийм муу зүйл биш шүү дээ. Уг нь капиталист эдийн засаг гэдэг чинь төвлөрөл байвал хамгийн сайн төвлөрч байж тэнд ажлын байр, бүтээмж, хамгийн бага зардал, масс үйлдвэрлэл олон зүйл болдог. Энийг дагаад эдийн засгийн эргэлт бий болдог. Өрсөлдөх чадвартай аж ахуйн нэгжүүд бий болдог. Төвлөрөл гэдэг чинь уг нь тийм муу зүйл бас биш шүү дээ. Энийг эдийн засгийн аргаар нь хэрхэн яаж өдөөж урамиуулж энийг бид нар урагшаа авч явах юм бэ. Гэтэл одоо яг төвлөрүүлнэ, татвар нэмнэ, хувийн өмчид халдана. Тэгэхээр энэ бүгд чинь яг бодлогын өөрчлөлт шинэчлэлт нь яг юу байгаа юм. Та нар нэг бараг л улс төрийн зорилготой, олон нийтэд лаг түгжрэлийг бууруулах юм байна, орон сууцжуулах юм байна гэдэг ийм гоё малгайтай хууль оруулчихаар олон нийт нэг юм хийх гэж байгаа юм байна гэж л харах юм байна л даа. Гэтэл яг эргээд иргэдийн эрхээс хэрхэн яаж булаах вэ гэдэг ийм л нөхцөл байдал. Зүй нь бол үнэхээр Улаанбаатар хотын асуудлыг ярих гэж байгаа бол нөгөө 2040 он хүртэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө маань хаачсан юм. Энэ том зүйлээсээ энэ бодлогын баримт бичгээсээ асуудал чинь эхэлдэггүй юм уу. Энэ хот гэдэг чинь өөрөө ийм нэг цул биет тийм амьд организм шүү дээ. Яг иж бүрэн энд тэндээс нь цөм явж болдоггүй. Тэгэхээр тэр ерөнхий төлөвлөгөө гэдэг тэр бодлогын баримт бичиг 2, 3 жил л ярьж байсан. Асуудал чинь тэр том бодлого, зорилт, концептоосоо асуудал чинь эхэлмээр санагдаад байх юм. Тэгэхээр тэр байхгүй ингээд өм цөм эрхийг булаана. Жишээ нь тэр газар чөлөөлөлтийн хууль. Энийг яг Үндсэн

хуулийн аль заалтыг баримталж байна. Та нар бол нэг гоё чөлөөлөөд бүтээн байгуулалт хийчихнэ гэхээр ард иргэд энийг зөв зүйтэй зүйл гэж бодож байж магадгүй. Гэтэл энэ чинь Үндсэн хуулийн зөрчил шүү дээ. Үндсэн хуулийн хэдийн хэдийг баримталж та нар яг энэ дээр асуудалд хандаж байгаа юм. Жишээ нь би харснаар Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг дээр хүний эрх, эрх чөлөө гэсэн бүлэг бий. Тэрдээр 19.2 дээр байна л даа. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлана гэж байгаа юм. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хуульд хуулиар хүний эрхийг хязгаарлаж болно. Тэгэхээр та нар аль эсвэл Улаанбаатартаа онц болон дайны байдал зарлах хэрэгтэй шүү дээ. Үнэхээр энэ хууль хэрэгжих гэж байгаа бол. Өөрөөр та нарт яг ямар ч энэ хуулийн заалт гараад Үндсэн хууль зөрчинө шүү дээ. Одоогийн яг нөхцөл байдлаар бол. Тэгэхээр энэ бүгд дээрээ нэг тайлбар хэлээч.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Сүүлийн асуултаас нь хариулъя. Улаанбаатар хотын одоо хэрэгжиж байгаа ерөнхий төлөвлөгөө бол 26 хувьтай л хэрэгжилттэй байгаа. Энэ хэрэгжилтийн бас олон асуудлууд нь бүтэц зохион байгуулалт, хөрөнгө мөнгөнөөс гадна ажлын уялдаа гээд түрүүн Батжаргал гишүүний хэлж байгаа юм байгаагаас гадна хууль, эрх зүйн асуудал нь тодорхойгүй гэдэг том дүгнэлт гаргасан юм байна лээ. Тэгэхээр бид хэд энэ хууль, эрх зүйн орчныг бас тодорхой болгож байж, дараа дараагийн хотын ерөнхий төлөвлөгөөгөө бас оруулж ирнэ. Үүнтэй бас зэрэгцээд уялдаатай явж байгаа гэдэг зүйлийг би бас Цогтгэрэл гишүүнд хэлье. Энэ зүйлүүдийг бас бид хэд цогц байдлаар нь харж байгаа. Зарим зүйлүүдийг нийслэл Улаанбаатар хот холбогдох яамдуудаараа дамжуулж Засгийн газарт

уламжилж, Улсын Их Хуралд бас өргөн мэдүүлэх гэдэг юм уу, танилцуулж байгаа учраас энэ бүх процессууд бол зэрэгцээд явж байна гэдэг зүйлийг бас танд хэлье.

Үндсэн хууль дээр бол хэд хэдэн заалт бий. Үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлана. Тийм учраас бид хэд та нар орон нутгийнхаа хэмжээнд шийдээд яваач ээ гэдэг асуудал бол байж болохгүй. Энэ Улаанбаатар хотод тулгамдсан, ялангуяа Улаанбаатар хот ч биш, ер нь орон нутгуудын тулгамдсан асуудлыг шийдье гэхээр дандаа хууль, эрх зүйн асуудал дээр очиж байгаа. Энэ цаана дандаа хүний өмчлөх эрх байдаг юм уу, үндсэн эрхүүдтэй холбогддог. Тэгэхээр бид хэд энэ асуудлыг бас тодорхой болгоё гэж байгаа. Тэгэхдээ энэ хязгаарлалт нь мэдээж үндэслэл бүхий хамгийн багаар тохиромжтой хэлбэрээр байх ёстой. 2 дугаарт нөхөн олговрыг заавал олгох ёстой байгаа. Тэгэхээр ийм зүйлүүдийг бид нар бас харгалзаж үзэж энэ хуулийн төслийг бас оруулж ирсэн.

Хотын эдийн засгийн асуудал өнөөдөр түгжрэл, орчны бохирдолтой шууд холбоотой байгаа. Өнөөдөр хотын эдийн засгийг боомилж байгаа асуудал мэдээж энэ ажлын уялдаа, энэ татвар төлөгчдийн бааз сууриа нэмж чадахгүй, бүртгэл энэ тэрээ хийж чадахгүйгээс гадна яг нийт байдлаараа энэ Улаанбаатар хотод явж байгаа аж ахуйн нэгж байгууллагууддаа энэ түгжрэлээс үүсэж байгаа тэр аж ахуйн нэгж байгууллагуудаас хохирлыг барагдуулах ажлыг хийж чадахгүй байгаа л байхгүй юу. Дэд бүтэц бүтээн байгуулалтаа хийж чадахгүй байна. Өнөөдөр магадгүй нэг хүргэлтийн компани өдөрт 3 хүргэлт хийх бололцоог бид нар бүрдүүлж өгч чадахгүй, нэг хүргэлтээ хийж байгаа учраас аж ахуйн нэгж байгууллагын орлого нэмэгдэхгүй байна. Энэ хэмжээгээрээ орон нутаг улсын төсөвт төлөх татвар байхгүй. Тэгэхээр бид хэд энэ түгжрэл гэдэг зүйлд

өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүний 9 хувийг алдаж байна. 2021 оны судалгаагаар 2,8 их наядын боломжоо бид нар алдчихсан байгаа. Тэгэхээр энэ хотын эдийн засгийг л дэмжихийн тулд энэ хууль бас орж ирж байгаа гэдэг зүйлийг хэлье.

Тэгэхээр ийм л байгаа. Газрыг Засгийн газар төвлөрүүлж олгох гэж байгаа гэдэг зүйл энэ хууль дээр байхгүй гишүүн ээ. Засаг дарга хотын 6 дүүргийнхээ асуудлыг цэгцэлтэл ямар ч байсан төвлөрүүлж шийдье ээ гэж байгаа юм.

2 дугаарт газар чөлөөлөлтийн асуудал байна. Газар чөлөөлөлтийн эрх зүйн орчныг би сая Үндсэн хуулийн заалтыг бас танд хэллээ. Энд эргээд энэ хуулиараа тодорхой болгож байж ямар хөрөнгийн үнэлгээтэй дэс дараалал зарчмын дагуу авах вэ гэдэг зүйлийг шийдэхгүйгээр орон нутаг бол тохиролцоод явахад бол маш хүнд. Тохиролцоод явах юм бол өөрсдөө бас буруутаад байгаа. Хууль, эрх зүйн талын үндэслэлгүй учраас. Тийм учраас энэ ажлууд ингээд гацчихсан. Зарим замын ажлууд 9-хөн айлаас болоод гацчихсан байх жишээний. Том тэр тойрог зам, метро, ер нь энэ орон сууцжуулах асуудал дээр газар чөлөөлөлтийн асуудлуудаа бас тодорхойгүй байгаа учраас яаж байгаа юм. Ттвар нэмж байгаа зүйл байхгүй. Авто зам ашигласны төлбөрийн тухай хууль гээд угаасаа байгаа. Энэ хуулийн зүгээр тодорхой түгжрэлтэй хэсэг буюу тодорхой цагуудад л нэмэлт төлбөр авах тухай асуудал байгаа. Түүнээс биш шинэ төрлийн татвар гаргаж ирсэн асуудал энэ хуулиар огт байхгүй.

Худалдан авах ажиллагаатай юу байгаа. Энэ нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын хуулийг батлахдаа тендерийн хуулийн 3.12 дугаар зүйл дээр энэ хуулиар зохицуулахгүй гээд хэлчихсэн чинь аль ч хуулийн зохицуулалтгүй болчихсон эд байхгүй юу. Тэгээд энэ

зөрчлийг нь бид нар арилгаж шууд худалдан авалтаар хийж явж байгаа юм. Тэгээд энэ хууль бол үндсэндээ батлагдсан тохиолдол бол 1 сар үргэлжлээд дуусах цаашдаа нээлттэй тендерийнхээ худалдан авалтаар явах ийм зохицуулалт байгаа юм. Энэ 2 хуулийн зөрчлийг л гаргаж өгч байгаа юм. Энэ 2021 онд орж ирсэн заалт шүү дээ, гишүүн ээ. Тэгэхээр бид хэд энэ тодорхойгүй ийм эрх зүйн орчнуудыг л бас нэг талдаа гаргаад шийдье л гэсэн ийм зорилго байгаа. Түүнээс биш дараагийн хууль бус зүйлийг хийх гээд ч юм уу, янз бүрийн байдлаар ийм зүйл байхгүй байгаа гэдэг зүйлийг бас танд хэлье ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн дахин тодруулъя.

О.Цогтгэрэл: Саяын асуудал асуултууд дээр тэр газар чөлөөлөх дээр хүний эрх эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно гэдэг нэг ийм бүтэн өгүүлбэрийн талыг нь та аваад хэлчхээд байна л даа. Үүний чинь урд талын үг нь онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлана л гэж байгаа шүү дээ. Яагаад тэр өгүүлбэрийг нь, тэр үгийг нь хаячхаад, дараа нь энэ хууль чинь Үндсэн хуулийн цэцэд очвол яг яах юм бэ. Нэг өгүүлбэрийг нь талаас нь аваад уншчихаад гишүүдэд ийм мэдээлэл бас өгч болохгүй шүү дээ. Онц болон дайны байдал. Улаанбаатарт тэгвэл залгаад онц болон дайны байдал зарлах гээд байна уу. Тэгээд саяын тэр хуулиуд бол үнэхээр бүгдээрээ тэгээд асуудалтай яг л төвлөрүүлсэн олон зүйл. Сая тэр Засгийн газарт төвлөрүүлэх гэдэг чинь төсвийн хуулийг дагаад л орж ирсэн, яг энд зориулсан л хууль шүү дээ гэх мэтийн нэг ийм ийм нөхцөл байдлууд яваад байна. Тэр ерөнхий төлөвлөгөө гэдэг зүйлээсээ л миний хувьд асуудал эхлэх ёстой л гэж боддог. Ерөнхий бодлого концептоо тавихгүйгээр ингэж өм цөм асуудалд хандаж болохгүй ээ. Улаанбаатар хот

хэдэн хүн амтай болох юм. Өнөөдөр хүн амын.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Ажлын хэсэг 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Үндсэн хуулийн 16 дугаар зүйл дээр бас ийм заалт байгаа. Төр түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөн олговор үнийг төлнө гэдэг заалт байгаа. Энэ өөрөө эргээд газрыг чөлөөлөх асуудал энэ хүрээндээ бас яригдаж байгаа. Ер нь гагцхүү хуулиар л хязгаарладаг. Хуулиар хязгаарлахдаа хүний үндсэн эрх чөлөө буюу амь насыг хязгаарлах асуудал, шаашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрхийг хязгаарлаж болохгүй гэдэг тэр заалттай уялдадаг. Тэгэхээр энэ асуудлуудыг бол тодорхой хэмжээнд Үндсэн хуулийн боломж нь бол байгаа юм гэдэг зүйлийг бас танд хэлье. 2040-ийн асуудал дээр бас ойлгож байгаа. Тэгээд зэрэгцүүлээд бид хэд явж байна гэдэг зүйлийг бас танд хэлмээр байна. Тэгээд энэ өмнөх ерөнхий төлөвлөгөө маань ерөөсөө 26 хувийн биелэлттэй. Энэ ерөнхий төлөвлөгөөг биелүүлэхийн тулд түрүүн бас гишүүдийн хэлээд байгаа саналыг ч гэсэн бид бодолцох ёстой. Ажлын уялдаа муу байна. Хөрөнгө мөнгөө тавьж өгсөнгүй. Өнөөдөр сүүлийн 10-аад жил Улаанбаатар хот руу дорвитой хөрөнгө оруулалт ер нь тавигдаагүй юм байна лээ. Өнгөрсөн 2, 3 жил дээр л Засгийн газраас жоохон анхаарал хандуулж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг. Хүний эрх, эрх чөлөө гэсэн бүлгийн 19.2-ыг та нар микрофонд унши даа. 19.2 дээр яг юу гэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: 19-ийг би танд яг бүтнээр нь уншиъя.

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль, эрх зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн хэсгийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. Энэ заалтыг бид нар явж байгаа. Энэ заалтын тодруулга нь онц олон дайны байдал зарласан үед. Энэ бол тохиолдлыг нь зааж өгч байгаа юм. Нийтлэг байдлаараа төр иргэнийхээ тодорхой үндсэн эрхийг хангах, эдийн засаг, хууль зүйн баталгааг бүрдүүлэх ёстой. Энэ тохиолдолд Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно гэж байгаа юм. Дайн байлдааны үед. Энэ бол тухайн тохиолдолд байхгүй юу. Нийтлэг байдлаараа ч бас тодорхой хэмжээний эрх зүйн баталгааг бүрдүүлж өгөөрэй гэдэг зүйлийг 19.1-ээрээ унших юм бол танд байна.

Ж.Бат-Эрдэнэ: Сайнзориг дарга аа, та Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга байсан. Яг үнэндээ дуржигнатал хариулна гэдэг чинь сайн хариулт биш шүү дээ. Гишүүдийн хариулж байгааг ер нь цааш цаашаа бодолцоорой. Гишүүдийн хариулж байгаа яг хууль зүйн үндэслэлээр тэр талаас нь хариулж харахгүй бол одоо тэгээд хотын дэд дарга болонгуутаа, орлогч дарангуут болонгуутаа нөгөө хууль зүйн логик үндэслэлээсээ эргээд буцаж байгаа юм биш үү. Тийм л зүйл харагдаад байна шүү. Энэ дээр ер нь дараа дараагийнх нь хариулт энэ ажлын хэсэг дээр бас анхаараарай.

Иингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцэж эхэлье. Ингээд гишүүд та бүхэн тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй саналыг бол хэлж болно.

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

3.Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

4.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

5.Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

6.Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Ингээд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

13.12 цаг.

Дараагийн асуудал. Чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Батжаргал гишүүн, Туваан гишүүнээр тасаллаа.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ Богд хаан уулын дархан цаазат газрын талбайн хэмжээг нь бууруулахгүйгээр хилийн цэст нь өөрчлөлт оруулах тухай асуудал нэг дүгээр заалтаар хөндөгдөж орж ирж байгаа юм. Тэгээд энэ дээр

ажлын хэсэг ажиллаад явбал нэг их өөрчлөх юм олдож өгөхгүй байна гээд байгаа шүү дээ. Тэгээд энэ та хэд ер нь яаж өөрчлөнө гэж бодоод байна. Энэ чинь одоо 2, 3 тоо яваад байдаг. Байгаль орчны яам дээр 1, Нийслэл дээр 1, Юнескод бүртгэгдсэн талбайн хэмжээ нэг өөр. Энэ чинь нийтдээ 42 мянга хэд билээ га-аар ингээд яваад байдаг. Тэгээд одоо ер нь та нарын энэ заалтыг боловсруулж оруулж ирэх хүрээнд хэдий хэмжээний га талбайг бид хил хязгаарыг нь өөрчлөх замаар шийднэ гэж хараад байна вэ. Үүнийг тодорхой хариулт авмаар байх юм.

Ж.Бат-Эрдэнэ: Хариулт. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Өөрийгөө танилцуулаарай.

П.Сайнзориг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч П.Сайнзориг байна.

Юнескод Богд хаан уулын дархан цаазат газрыг Юнескод бүртгүүлэхдээ 41.650 га-р бүртгүүлсэн байдаг юм байна лээ. Газрын шинэтгэлийн үндэсний хорооны хурлаар оруулсан хилийн зааг бол 41.423,4 га, Байгал орчин, аялал жуулчлалын яам дээр ашиглагдаж байгаа нь 42.000 га руу явж байгаа. 42.192,4 га. Нийслэлийн газрын албан дээр байгаа бол 41.089 га гэдэг зөрүүтэй 4 тоо явж байгаа. Тэгэхээр түрүүн бас Энхтүвшин гишүүний хэлж байсан тодорхой ажлын хэсгүүд ажилласан.

Яармар, Хан-Уулын хэсгээс бас тодорхой хэмжээний ойлголцолд хүрээд хилийн цэсийн координацыг тэмдэгжүүлэлтийн хувьд буруу хийсэн юм байна. Энэ дээр тодорхой хэмжээний Байгаль орчны яамны олгосон газруудыг нийслэл шилжүүлэх гэдэг юм уу ийм бууруулах асуудал яригдсан. Би түрүүн бас гишүүнээ 200 нэгж талбар гээд худлаа хэлсэн байна. 800 нэгж талбар юм байна. Уучлаарай. Мэдээллийг зөрүүтэй өгсөн байна. Тэгэхээр уг асуудлууд ингээд явагдаж байгаа.

Тэгэхээр ер нь нэгэнт бас Юнеско-д бүртгэлтэй ийм байгаа учраас зайлшгүй хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулж, зарим бололцоог судлуулъя л гэж байгаа юм. Энэ дээр газрын хэмжээг бууруулахгүйгээр Юнескод бүртгүүлсэн хэмжээнд нь бариулж судлуулж хилийн цэсийг дахин тодотгох бололцоо байна уу гэдэг зүйлийг л Засгийн газарт уг тогтоолоор өгье. Бид Засгийн газар дээрээ яг нийслэл, Байгал орчны яам болон холбогдох Барилга хот байгуулалтын яамтайгаа яг газар дээр нь бодит байдлаар асуудалд хандъя гэсэн ийм зорилгоор оруулж ирсэн. Энэ тогтоолын 1 дэх заалтыг.

Ж.Бат-Эрдэнэ: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Ер нь их сонин шүү дээ. Энэ Дархан цаазат газар дотор Улаанбаатар өөрийнхөө хилийн цэст орсон дотор бол ер нь овоо юм барьсан юм билээ. Тэгээд одоо өөрчлөнө гэвэл бусдын хилийн цэс рүү л орох гэж оролдоно. Яг үнэндээ. Гэтэл нөгөөдүүл нь бас угтуулаад улсын тусгай хэрэгцээнд аваад шинэ хотын ч хийчихсэн. Олон Улсын нисэх буудлын зориулалтаар ч улсын тусгай хэрэгцээнд аваад хийчихсэн. Эдийн засгийн чөлөөт бүсийн зориулалтаар ч улсын тусгай хэрэгцээнд авчихсан. Тэгээд наадах чинь автозам элдэв бусын юмаараа шахагдаад бас тухайн нэгжүүд өөрийнхөө аж ахуй зохион байгуулалт, иргэдийн эрх ашгийн үүднээс өөрийнхөө тусгай хэрэгцээний газартай давхцаагүй хэсэг дээр газар олголт хийчихсэн. Тэгээд яах юм. Нийслэлийн мафантай асуудлыг шийдээд, бусад нь өөрийнх дээрээ дахиад эрх зүйн зөрчилтэй асуудал татаж орж ирэх юм уу.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг. 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Тэгэхээр гишүүн ээ, бид хэд бол энэ дээр Засгийн газарт өгч

байгаа юм дээр судлан л гэж байгаа. Судлан шийдвэрлүүлэх. Ямар дүгнэлт гарах вэ, үнэхээр боломж нь байна уу, үгүй юу. Яг яах аргагүй хот, нийтийн аж ахуйг Зайсангийн ам гэлтгүй тодорхой Богд уулын дархан цаазат газар хүргээ гэхээр бид хэд энэ дээр хөрөнгө, мөнгө тавих эсэхээс эхлээд эргэлзээтэй. Шинэ хороо байгуулах уу. Ер нь практикаараа заримдаа байгуулсан яваа. Сургууль, цэцэрлэг барих уу, үгүй юу. Эргээд зам арчлалтыг нь хэн хариуцах вэ. Гэрэлтүүлгийг хэн хариуцах вэ. Хогны менежмент болон газар доогуур явж байгаа шугам сүлжээний асуудлыг хэн хариуцах вэ ч гэдэг юм уу ингээд маш олон асуудлууд байна. 2 дугаарт бас энэтэй холбоотойгоор орчны бохирдлын асуудлууд үүсэж байгаа. Нөгөө төвлөрсөн бус өөрөө бие даасан байдлаар дэд бүтцээ шийдсэн юмнууд дээр бохирын асуудлууд нь маш хүндрэлтэй болоод ирсэн юм байна лээ. Зарим аж ахуйн нэгж байгууллагууд нь СӨХ-дөө хариуцуулаад явчихсан. Тэр нь хальдаг. Хэн хариуцах нь мэдэгддэггүй ч байдаг юм уу. Маш олон тулгамдсан асуудал байгаа юм аа. Тэгээд бид хэд.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Туваан гишүүн.

Ц.Туваан: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Их Хурлын тогтоол оруулж ирж байгаа юм байна. Тэгээд энэ дээр Богд хаан уулын дархан цаазат газрын хилийн заагийн хэмжээг хилийн цэст өөрчлөлт оруулна гэж байгаа юм. Тэгээд л яг ингээд л явдаг юм л даа. Ингээд л эхлээд авдаг байхгүй юу аль нэгийг нь. Тэгээд Богд хаан дархан цаазат газарт өөрчлөлт оруулах асуудлыг нь эрхийг нь авч байгаад л, тэгээд л дараагийнхаа газар луу дайрдаг. Энэ чинь ерөөсөө тодорхой асуудал шүү дээ. Төв аймаг Богд хааны уулын дархан цаазат газар чинь ерөөсөө аймгийн хойд талаар оччихсон байж байгаа. Аймагт Зуунмодод ер нь та нар явж яг үзсэн үү, үгүй юу. Яг хойд талд нь тулчихсан байж байгаа. Одоо тэгээд энийг хилийн

цэс өөрчлөхөөр тэгээд хаашаа юм Зуунмодыг оруулж авах юм уу.

2 дугаар асуудал яг ингээд дагаад гэж би хэлээд байгаа нь болохоор Төв аймгийн Эрдэнэ сумтай гэхэд жишээлбэл 64 мянган га-ийн газрын маргаантай асуудал. Баян сум, Сэргэлэн сум, Алтанбулаг, Аргалант, Баянхангай, Баянчандмань гээд явдаг байхгүй юу. Тэгээд энэ бүх болгон дээр та нар дандаа л ингээд хүч түрээд өөрсдийнхөө шийдвэрийг тулгаад асуудлуудаа шийдээд шийдээд явчихдаг. Тэгэхээр тэрний эхлэл нь энэ болох гэж байна гэж ингэж хараад байгаа юм. Ингэж хардаж байгаа юм. Иргэд маш олон байдлаар энэ асуудлыг тавьж байгаа.

Дараагаар нь энэ дээр ингэж байгаа юм 2 дугаар заалт дотор чинь газар албадан чөлөөлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан тул гээд. Та хэд дараагийнхаа авах тэлэлтийнхээ арга хэмжээг 2 дугаар заалт дотор оруулчихсан байгаа байхгүй юу. Харилцааг зохицуулсан тул цаашид улсын хэмжээнд нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар албадан чөлөөлөхтэй холбоотой асуудлыг гээд л явчихдаг байхгүй юу. Тэгэхээр энэ чинь бид нар хардахаас өөр яах юм бэ. Энэ дотор чинь ямар нэгэн тийм харилцан ойлголцол Төв аймгийнхантай зохицуулах түрүүний тэр гоёор яриад байсан нөгөө нэг аль аль хэн хэнийхээ эрх ашгийг хамгаална гэсэн юм чинь байхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр манай Байнгын хорооныхон ч гэсэн энэ асуудал дээр нэлээн анхааралтай хандаад тэгээд энэ Засгийн газар чиглэл авч байгаад ингээд энэ бол ганцхан өнөөдөр Төв аймаг дээр яригдаад байгаа боловч энэ чинь тэгээд бүх л аймгууд дээр яригдана шүү дээ. Тэгээд л Сумын иргэдийн Хурал, Аймгийн иргэдийн Хурлаар энэ асуудал ордог. Өгөхгүй ээ, шийдэхгүй ээ, болохгүй ээ гээд л оруулаад ирэхээр Засгийн газар дээр тас гээд л цохиод л, 10, 20 мянган га-гаар нь л авчихдаг шүү дээ. Тэгээд энэ дотор бол ямар нэгэн тийм консенсус зөвшилцөл юм

хум бол харагдахгүй байна шүү. Тэгэхээр манай Байнгын хорооныхон бас энэ чиглэл өгөх тухай тогтоолыг бас нэлээн анхаарч үзээрэй. Бүр аль хэзээний шийдээд цаашилуулаад явж байгаа асуудал 2 дугаар заалт дотор чинь байна шүү. Энийг юу гэж үзэж байгаа вэ. Ажлын хэсгээс асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Туваан гишүүний асуултад хариулъя. 2 дугаар заалт нь бол нөгөө түрүүн Дамдинням гишүүний асууж байсан асуулттай л холбоотой юм л даа. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулиар нийслэлийн хэмжээнд нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар албадан чөлөөлөхтэй холбоог зохицуулсан тул ер нь цаашидаа нөгөө нэгдсэн байдлаар үйлчлэх энэ хуулиа бас Засгийн газар яаралтай оруулж ир л гэдэг чиглэлийг бас өгүүлж байгаа юм. Бид хэд яах вэ, яг нийслэлийн асуудлыг дагаад нийтлэг байдлаар оруулж ирэхээр бас их зохимжгүй гэж үзсэн учраас Барилга, хот байгуулалтын яам нь энийг нийтлэг байдлаар оруулж ирээч. Тэгэх юм бол энэ хууль дагаад л бас хүчингүй болох буюу нэгдсэн тэр хууль руугаа л шилжээд орчихно гэсэн санааг аль болохоор түргэвчлүүлэх үүднээсээ л оруулж ирж байгаа юм. Тэгэхээр яах вэ, аль нэг засаг захиргааны нэгжээс газар авах асуудал бол шууд Засгийн газрын хэмжээний асуудал биш байх л даа. Энэ Улсын Их Хурал дээр бас аймаг хооронд болон нийслэл Улаанбаатар хотын хилийн цэсийг тогтоох асуудал угаасаа байдаг. Зүгээр улсын тусгай хэрэгцээнд авах уу, үгүй юу гэдэг бас тодорхой зохицуулалтууд бол бий. Тэгээд энэ дээрээ мэдээж тодорхой газрын хууль болон Засгийн газар нэгжийн хуулийнхаа хүрээнд бас тодорхой саналыг нь авсны үндсэн дээр тодорхой зохицуулалтууд явж байгаа. Эдгээр зохицуулалтуудыг боловсронгуй

болгох асуудал та хөндөж байна. Энэ бол зөв. Ер нь бол аль болохоор аль аль талынхаа эрх ашгийг тэнцвэртэй хангасан ийм бодлогоор газрын дагасан энэ хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх гэдэг бол чухал байгаа. Энэтэй бол санал нэг байгаа гэдэг зүйлийг танд хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Би түрүүн хэлсэн шүү дээ. Сайхан сайхан хариулт л өгөөд байх юм. Дуржигнатал хариулт өгөөд байх юм. Яг тодорхой асуугаад байна шүү дээ. Тэр яаж өөрчлөх гээд байгаа юм гэдгийг нь. Туваан гишүүн дахин тодруулъя.

Ц.Туваан: Яах вэ, би түрүүний тэр Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дээр яг ийм л утгаар хэлсэн байхгүй юу. Одоо ингээд яг энэ асуудал чинь нэг ийм Нийслэлийн бид хэд гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл сааруулах гэж орж ирж байгаа боловч яг газартай холбоотой асуудал чинь яригдаад явахаар ингээд л бүх харилцаанууд чинь босоод ирдэг байхгүй юу даа. Тэгээд тийм юман дээр сэглэж яах гээд байгаа юм бэ. Одоо энийгээ тийм юм бол төсөв хэлэлцээд баталчихсан. Одоо энэ асуудлуудаа цогцоор нь ярьж байгаад оруулж ирээч ээ. Тэгэхгүй болохоор таны саяын хариулт дотор чинь 2 дугаар заалтаараа бид нар дахиад ухарсан Барилга, хот байгуулалтын яамтай юм ярих гээд, ингээд нөгөө Газрын тухай хууль оруулж ирэх гэж байгаагийнхаа яг эсрэг юм ярьж байгаа байхгүй юу. Буцаад тэр том хууль руу зохицуулалтыг нь хийх асуудлыг оруулж ир гээд. Ингээд ажлын хэсэг дээрээ хүртэл яг ийм байдалтай байна. Тэгэхээр газрын хууль яг ийм байхгүй юу даа. Тэгэхээр цогцоор нь сэглэлгүйгээр бүтнээр нь.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Санал уу. Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Би Үйлдвэр технологийн паркттай холбоотой хуулийг л ярих гээд байгаа юм. 2022 оны 8 сарын

1-нд Үйлдвэр технологийн паркийн хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байж байгаа. Тэр дээр улсын чанартай үйлдвэр технологийн паркийг Монгол Улсын Засгийн газар зарлахаар байж байгаа. Орон нутгийн чанартай үйлдвэр технологийн паркийг нийслэл, аймгийн Засаг дарга зарлаад, газрыг нь тухайн шатын иргэдийн Төлөөлөгчийн Хурал олгохоор ингээд заачихсан байж байгаа. Энэ бол танай тодорхой асуудлуудыг шийдэж өгөх бололцоо боломжтой шүү. Түрүүн ярилаа шүү дээ. Тусгай хэрэгцээнд аваад, тэгээд хөдөө аж ахуйн үйлдвэр технологийн паркаа гаргадаг ч гэдэг юм уу. Хөнгөн үйлдвэрлэлийн үйлдвэр технологийн паркаа гаргадаг ч гэдэг гэдэг ч юм уу. Энэ нийслэл Улаанбаатар хотод байж байгаа үйлдвэрүүдээ бас гаргах тийшээгээ дэд бүтэц татах асуудлыг ч гэсэн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ийм эрх зүйн орчныг гаргаж өгсөн юм байж байгаа шүү дээ. Тэгээд энэ хуулийг ерөөсөө хүмүүс уншдаггүй. Энэ үйлдвэр технологийн парк бол нэлээн том энэ газартай холбоотой, дэд бүтэцтэй холбоотой томоохон эрх зүйн орчныг нээж өгсөн ийм хууль шүү хууль шүү. Тэгэхээр энэ бас танай энэ төвлөрлийн асуудал дээр нэлээн их нэмэр болох байх. Сая Монгол Улсын Засгийн газар хүнд үйлдвэрлэлийн 2 үйлдвэр технологийн парк зарлачихлаа. Хөнгөн үйлдвэрлэлийн 2 үйлдвэр технологийн парк зарласан шүү дээ. Ховдод 1, Дорнодод 1 хүнд үйлдвэрлэлийн Дорноговь аймагт 2 үйлдвэр технологийн парк зарлачихлаа. Орон нутаг орон нутгийн Засаг дарга бас орон нутгийн зэрэглэлтэй үйлдвэр технологийн паркаа тусгай хэрэгцээнд аваад зарлах, тийшээгээ дэд бүтэц татах асуудал чинь ч хүртэл нээлттэй байгаа шүү гэдгийг л хэлмээр байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. 2 асуулт байна. Сайнзориг дарга аа. Энэ 1 дээр хар даа. Богд хан уулын дархан цаазат газрын хилийн заагийн хэмжээг гэж байгаа шүү. Бууруулахгүйгээр

заагийн хэмжээг нутаг дэвсгэр биш шүү. Хилийн цэсэд өөрчлөлт оруулахыг судлан шийдвэрлүүлэх гээд байна. Хилийн цэс, зааг 2 чинь ямар ялгаатай юм бэ. 1 дүгээр асуулт.

2 дугаарт 2 дугаар заалт дээр зайлиггүй газар албадан чөлөөлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан тул цаашид улсын хэмжээнд нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар албадан чөлөөлөхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулж яаралтай Монгол Улсын Их Хуралд өргөн барих мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнэ-д даалгасугай гэж байгаа юм.

Үгүй ээ, тэгээд дахиад 1 хууль орж ирэх гээд байна тийм үү. Миний ойлгож байгаагаар. Одоо энэ хуулиа яаралтай яаралтай гээд та нар хэлэлцүүлэх гээд оруулаад ирлээ. Тийм байгаа биз. Улсын Их Хурлын гишүүдэд үнэхээр албадан хийх, албадан булаах юу гэдэг юм түрүүний гишүүдийн тодорхойлолтоор ийм албадсан хууль оруулаад ирлээ шүү дээ. 2 дахь хууль гэсэн Улсын Их Хуралд 2023 оны 12 сарын 1-ний дотор багц хуулиа оруулаад ир гээд Оюун-Эрдэнэ сайдад даалгачихсан. 3 дахь нь дахиад энд зохицуулалттай хуулийг дахиад оруулаад ир гэсэн ийм юм оруулаад ирлээ шүү дээ. Яагаад энийгээ сая энэ дотор оруулж ирж чадаагүй юм. Тэгээд энэ албадан чөлөөлөхтэй холбоотой гэж байгаа шүү. Дахиад нэг ийм юм орж ирэх гээд байгаа юм уу. Энэ дээр нэг хариулж өгөөч. 2 номерын микрофон. Ажлын хэсэг.

П.Сайнзориг: Бат-Эрдэнэ даргын асуултад хариулъя. Уг Газрын хуулийн нэмэлт, өөрчлөлт бол зөвхөн Улаанбаатар хотод үүсээд байгаа энэ дэд бүтцийн бүтээн байгуулалт буюу нийгмийн зайлиггүй хэрэгцээнд газар албадан чөлөөлөхтэй харилцааг зохицуулж байгаа юм. Тэгэхээр уг харилцаа нийтлэг байдлаар Монгол

Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх хууль, эрх зүйн орчин зайлиггүй шаардлагатай байгаа. Энэнийхээ хүрээнд нийтлэг зохицуулалттай хуулийг нь яаралтай оруулж ир л гэж байгаа юм. Бид хэд яг энийг нийтлэг байдлаар оруулчихаар Улаанбаатарын хуулийг дагаад газрыг нийгмийн зайлиггүй хэрэгцээнд албадан чөлөөлөх тухай хууль гээд бүхэл бүтэн оруулж ирэхэд зохимжгүй гэж үзсэн. Тэгэхээр энэ Газрын багц хуулийн 1 хууль нь Газрын ерөнхий хууль, Газар албадан чөлөөлөх тухай хууль, Газар өмчлүүлэх тухай хууль гээд ийм зэрэг 5 багц хууль явж байгаа юм. Энэ хуулийнхаа 1 хэсэг нь болгож энэ нийтлэг байдлаар үйлчлүүлэх хууль. Тэгэхээр яах вэ, зүгээр өргөн барьсны дараа тэр хууль маань ямар байдлаар хэлэлцэгдэж хэдэн оноос яг үйлчилж эхлэх асуудал нь өөрөө Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал байгаа учраас бид хэд тэр хуулийг бас хүлээх боломжгүй байгаад байгаа. Нэгдсэн ийм зохицуулалтыг Улаанбаатарын хэмжээнд хийж авч хэрэгжүүлээд явж байя. Тэр хууль нэгдсэн байдлаар цаашидаа нийтлэг байдлаараа үйлчилж зохицуулах юм байна гэдэг байдлаар энийг Засгийн газарт үүрэг өгөөд байгаад байгаа юм. Нэгдсэн байдлаар бас оруулж ирээрэй гэж. Тухайлан Улаанбаатар асуудлыг тухайлан зохицуулаад хаячхаж болохгүй ээ л гэсэн санааг бас давхар хэлсэн юм.

Ж.Бат-Эрдэнэ: Цэс нөгөө зааг 2.

П.Сайнзориг: Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль дээр бас ийм хэд хэдэн нэр томъёо ойлголтууд яваад байгаа юм. Тэгэхдээ бид хэд энийг хэлэлцүүлгийн явцад бас анхааръя. Ер нь зүгээр хилийн заагийг тогтоох саналыг судалгаанд үндэслэн боловсруулж тухайн шатын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэх гээд бас нэг ойлголт, цэс гээд бас Газрын хууль болон юмаар ингээд явж байгаа. Тэгэхээр эдгээр хуулиудынхаа нэр томъёонд нийцүүлээд энэ найруулгыг хийсэн байгаа. Тэгээд яг таны хэлж байгаа саналыг бид нар

хэлэлцүүлгийн явцад анхааръя. Эдгээр хуулиудын нэр томъёо энэ тэр ч бас зарим талаараа давхацдаг, зөрүүтэй ойлголтуудыг үүсгэж болохоор юмнууд байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Зааг цэс 2 адилхан уу гэж асуусан шүү дээ би. Өөр юм уу.

П.Сайнзориг: Тусдаа.

Ж.Бат-Эрдэнэ: 1 юм биш шүү.

П.Сайнзориг: Энэ болохоор нэг нь болохоороо хилийн цэс дээр болохоор нэгжийн хувьд ойлголцоод байгаа. Энэ Төв аймгийнх уу, Улаанбаатрынх уу. Гэтэл энэ тусгай хамгаалалттай газар нутгийн зааг гэдэг нь хэд хэдэн нэгжүүдийг бас дамнаж байгаа. Энэ яг тусгай малтай газар нутгийн хуулийнхаа 29 дүгээр зүйл дээр байгаа ойлголт, нэр томъёолол байгаад байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Заагийн хэмжээг бууруулах гэдэг чинь юу гэсэн үг юм бэ. Харин тэр чинь ойлгохгүй байна шүү дээ. Заагийн хэмжээг бууруулах. Талбайн хэмжээг бууруулахгүй байж болно. Заагийн хэмжээг бууруулахгүйгээр цэсийг нь өөрчилнө гээд нэг л ийм зурвасыг л бууруулахгүйгээр явна гэсэн наад үг үсэг чинь болохгүй байгаад байгаа юм биш үү. Энэ дээрээ өөрсдөө эргэж хараач. Гүрийгээд л тачигнатал хариулаад байх юм.

2 дугаарт энэ хар даа. Яг өөрийн чинь тайлбарлаж байгаагаар дараагийн орж ирэх чинь нийтлэг том хууль орж ирэх юм байна. Энэ бол яг Улаанбаатарт зориулсан хууль орж ирэх гээд байна шүү дээ. Газрын. Логикийн хувьд энэ зөв гэж үзэж байна уу та. Хууль зүйн Төрийн нарийн байсан хүн. Бусад аймгуудад бол үйлчлэхгүй. Зөвхөн Улаанбаатар хотод энэ нь үйлчилнэ. Яг ийм хэмжээний бүтээн байгуулалт явуулах гэхээр одоо яах юм Өвөрхангай дээр, Булган дээр дахиад шинэ хууль гарах юм уу. Нийтлэг

нь өөр байх юм уу. Ийм асуудал гарч ирээд байна шүү дээ.

П.Сайнзориг: Тийм үнэн үнэн. Тэгээд яг энэ нийтлэг байдлаар оруулъя гэхээр Барилга, хот байгуулалтын яам нэгдсэн байдлаар бид оруулна гэсэн. Зөвхөн Улаанбаатарынхаа асуудлыг та хэд зохицуулаад явах хуулийн төслөө боловсруул гэдэг байдлаар ойлголцсон. Тэгэхээр ер нь Газрын багц хуулийг дагаад энэ дээр нэг хууль нь бас таны хэлж байгаачлан яг нэгдсэн байдлаар Монгол Улсын хэмжээнд үйлчлэх хууль орно. Тэгсэн тохиолдолд магадгүй Газрын хуулиасаа энэ зохицуулалт ч гэсэн алсдаа тэр хууль хүчин төгөлдөр болохоор хүчингүй болох байх. Тэгэхээр ер нь зүгээр хууль хоорондын мэдээж уялдааны асуудал нь цаг хугацаанаасаа бас.../минут дуусае/

Ж.Батжаргал: Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авлаа. Ингээд зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

“Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд танилцуулна.

13.32 цаг.

Нэг дүгээр асуудлаа одоо хэлэлцэнэ. Зарчмын зөрүүтэй 50 гаруй саналтай байгаа. Одоо хэлэлцүүлээд явах уу. Завсарлачихаар дараа нь заал олдохгүй юм байна. 14 цагаас энэ заал болон бүх заалууд юутай байгаад байдаг. Хэлэлцээд явчих уу. Хэлэлцээд явчихъя тэгэх үү.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсгийг урьж оруулъя.

И.Батчулуун Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Б.Мөнх-Эрдэнэ Улаанбаатар хотын Захирагчийн албаны Орчны бохирдол хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга, Б.Болдбаатар Мал эмнэлэгийн ерөнхий газрын Мал, амьтан эрүүл мэндийн газрын дарга, Ц.Гантөмөр Мал эмнэлэгийн хэлтсийн дарга, Б.Мөнхжаргал Улаанбаатар хотын Захирагчийн албаны Орчны бохирдол, хог хаягдлын хэлтсийн мэргэжилтэн, Б.Болд хуульч, Н.Баясгалан Өмгөөллийн Легалгайд ХХК-ийн эрх зүйч, Ц.Зориглон Азтай савар төрийн бус байгууллагын тэргүүн, Ц.Болормаа Азтай савар төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, М.Ариунзул Өмгөөлөгч, өмгөөллийн Эм Ди Эс энд Хаан лекс ХХН-ийн хуульч, Э.Анударь Азтай савар төрийн бус байгууллагын эрх зүйч, Д.Цэрэнханд Монгол банхар судлалын төвийн үүсгэн байгуулагч, А.Наранбаяр Монголын нохой судлалын холбооны тэргүүн.

Ингээд хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. Ажлын хэсгийн ахлагч Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ажлын хэсгийн танилцуулгыг танилцуулна. Цогтбаатар гишүүнд микрофон өгье.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Х.Нямбаатар, Ж.Сүхбаатар нараас 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн чуулганы

нэгдсэн хуралдаанаар хийж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн билээ. Уг хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 5 дугаар тогтоолоор байгуулж, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар миний бие ахлаад, гишүүдэд Т.Аубакир, Э.Батиугар, Г.Дамдинням, Ц.Туваан нар ажилласан.

Ажлын хэсэг 3 удаа, ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг давхардсан тоогоор 10 гаруй удаа хуралдаж гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийн талаарх холбогдох байгууллагуудын саналыг сонсож, нийт 44 зарчмын зөрүүтэй санал, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх 6 зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд танилцуулж байна.

Үүнд, гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд баримтлах зарчмыг тодорхой болгосон. Хөдөө орон нутагт амьдарч байгаа нохой, муурын асран хамгаалагч нь хот суурин газрын нохой, муурын асран хамгаалагчийн нэгэн адил сургалтад хамрагдах, шаардлагагүй байхаар тусгалаа.

Гурав.Уугуул үйлдвэрийн нохойтой холбоотой асуудлыг зохицуулах, дэмжихтэй холбоотой зохицуулалтыг тусгасан.

Дөрөв.Мөн төслийн асран хамгаалагч, түр байрлуулан асрамжлах газар нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа нохой, муурын нэгдсэн бүртгэл гэсэн нэр томъёог оновчтой болгож, холбогдох нэр томъёо бусад зохицуулалтуудад найруулгын шинжтэй засваруудыг оруулсан.

Тав.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн, өөрчлөн найруулсан. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтбаатар гишүүнд баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцье.

Гишүүд та бүхэн тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асуух болон зарчмын зөрүүтэй санал гаргаж болно.

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын томъёолол бэлтгэсэн.

Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль,” гэсний дараа “Иргэний хууль, Зөвшөөрлийн тухай хууль,” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.3 дахь хэсэг нэмэх:

“2.3.Энэ хууль албаны нохойтой холбоотой харилцаанд хамаарахгүй.” Санал хураалт. 54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын томъёолол бэлтгэсэн байна.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.2.“асран хамгаалагч” гэж гэрийн тэжээвэр амьтныг энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн хоол, орон байраар хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах болон нохой, муурыг өөрийн нэр дээр бүртгүүлсэн иргэнийг;

3.1.6.“түр байрлуулан асрамжлах газар” гэж төөрсөн, олдсон нохой, муурыг асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх хүртэл, эзэнгүй нохой, муурыг асран хамгаалагчтай болгох хүртэл хоол, орон байраар хангаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулан түр хараа хяналтдаа байлгах зорилгоор энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;” Санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.8, 3.1.9, 3.1.10 дахь заалт нэмэх:

“3.1.8.“нохой, муур үржүүлэх” гэж нохой, муурыг нэг болон түүнээс дээш удаа үржүүлэхийг;

3.1.9.“нохой, муурын нэгдсэн бүртгэл” гэж нохой, муурын асран хамгаалагч, нохой муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагааг;

3.1.10.“Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж” гэж гэрийн тэжээвэр амьтанд урьдчилан сэргийлэх арга хэмжээ, оношилгоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нохой,

мууранд үржил хязгаарлах мэс ажилбар хийх, бичил чип суулгах, шаардлагатай тохиолдолд унтуулах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан нэгжгийг;” Санал хураалт. Санал хураалтыг цуцлъя. Асуулт байна гэсэн тээ. Наранбаатар гишүүний микрофон өгье.

Н.Наранбаатар: Энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Тэгээд өмнө нь зохицуулагдаагүй маш олон зүйлүүдийг зохицуулаад оруулаад ирсэн байгаа. Асуулт юу байна гэхээр хөдөө орон нутагт байгаа малчдын нохой, тэжээвэр амьтныг яаж зохицуулах юм. Энэ дээр сая тэр чип энэ тэр гээд л төрснөөс нь хойш тэдэн сарын дотор мэс засал хийнэ энэ тэр гээд л ярьж байна. Хөдөөгөөр байгаа малчид маань ингээд байж чадах уу, үгүй юу. Бололцоо байгаа юу. Яаж зохицуулах вэ. Төв суурин газартай ялгаатай байна уу. Тэгээд зөрчлийн хуулиар хэрвээ тэгээгүй бол торгоно, хариуцлага хүлээлгэнэ гээд байгаа. Тэгээд зөрчлийн хуулиар бас торгуулах, хариуцлага хүлээх асуудлууд гараад ирэхгүй байгаа гэсэн нэг асуулт байна. Тэгээд тусгай зөвшөөрөлтэй холбоотой тэр үржүүлгийн газарт тусгай зөвшөөрөл өгөхдөө ямар ямар шаардлага хангасан байх ёстой юм. Хүнд суртал дахиад нэмэгдэж байгаа юм биш үү гэсэн 2 асуулт байна.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтбаатар гишүүн хариулъя.

Д.Цогтбаатар: Хөдөө орон нутгийн яг малчдын асуудлыг бид нар энэ хуулийн төслийг хэлэлцэж байхдаа тусгайлан авч хэлэлцсэн. Тийм учраас хот суурин газрын гээд бүр тусгай ойлголт оруулаад ирсэн байгаа. Тэгэхээр хөдөө орон нутгийн малчдад энд заагдсан бүх шаардлагууд хамрахгүй. Жишээлбэл, мал эмнэлэгийн үйлчилгээ үзүүлж байхдаа хот суурин газрынхан бол сургалтад суух ёстой бол хөдөө орон нутагт бол мал эмнэлэгийн тэр тэргүй

үйлчилгээ үзүүлж байгаа шүү дээ. Тэр хүмүүс маань муур, нохойтой холбоотой зөвлөмж өгөөд явчих боломжтой байж байгаа. Энэ чипний тухайд гэвэл угаасаа тэртээ тэргүй малыг чипжүүлэх гээд л ярьж байгаа шүү дээ. Тийм учраас нохой муурыг чипжүүлэх юм нь аль болох ачаалалгүйгээр хийх боломжтой гэж бид нар үзэж байгаа юм. Энэ үржүүлгийн газрын тусгай зөвшөөрлийн тухайд гэвэл Тусгай зөвшөөрлийн хуультайгаа бид нар уялдуулж энийгээ боловсруулсан байгаа. Тэгээд энэ дээр бол мэдээж тодорхой шаардлагууд бол жишээлбэл нохой, муураа өсгөх үржүүлэх газар гэхэд гэрэлтүүлэг сайтай, амьтад тодорхой зайнд чөлөөтэй амьдрах боломжтой байх, эрүүл ахуйн шаардлагуудыг хангасан байх эсхүл хүүхдийн сургууль, цэцэрлэгийн газраас тэдэн метр зайтай гээд зааж өгөх тиймэрхүү шаардлагуудыг тавьсан байгаа. Ажлын хэсэг нэмж хариулах бол хариулна биз.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хураалт. 45.5 хувиар санал дэмжигдсэнгүй. Дамдинням гишүүний микрофоныг нээе.

Г.Дамдинням: Дарга аа, саяын гарсан саналыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Би сая санал өгөх гэсэн чинь амжсангүй.

Ж.Бат-Эрдэнэ: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн Дамдинням гишүүний саналаар санал хураалт. Хүчингүй болгох санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ. Хүчингүй боллоо. Дахин санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан 1 санал байна.

4.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл. Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд баримтлах зарчим

4.1. Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1. энэрэнгүй хандах;

4.1.2. хүчирхийллээс ангид байлгах;

4.1.3. байгалиасаа өөрийн онцлогтой болохыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, халамжлах;

4.1.4. гэрийн тэжээвэр амьтныг гэршүүлэн тэжээж ирсэн Монголын ард түмний уламжлалт ахуй, ёс заншил, өв соёлын салшгүй нэг хэсэг болох үндэсний уугуул үүлдрийн нохойтой холбоотой өвөрмөц аж төрөх ёс, түүхэн уламжлалыг хадгалах, нандигнан өвлүүлэх.” Санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс 1 санал байгаа.

*Төслийн 2 дугаар бүлгийн гарчгийг “**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ АСРАН ХАМГААЛАГЧ БОЛОХ ҮНДЭСЛЭЛ, АСРАН ХАМГААЛАГЧ, ТҮР ХАРАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**” гэж өөрчилж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:*

“5.1. Иргэнд гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч болох үндэслэл дараах байдлаар үүснэ:” Санал хураалт. Болохгүй байна. Техникийнхэн анхаараарай. Программ гацсан байна. Санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал байна.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “6.1-д заасан шаардлагаас гадна асран хамгаалагчийн” гэснийг “7 дугаар зүйлд заасан” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.3 дахь хэсэг нэмэх:

“6.3. Иргэн гэрийн тэжээвэр амьтны талаарх ойлголт авах зорилгоор сайн дураараа асран хамгаалагчийн сургалтад хамрагдаж болно.” Санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

7. Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “энэ хуулийн” гэсний өмнө “хот, суурин газарт” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.4 дэх хэсэг нэмэх:

“7.4. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь хот, сууринаас бусад газарт энэ хуулийн 7.3-т заасан агуулга бүхий зөвлөмж, мэдээллийг өгнө.” 54.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан 1 санал байна.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “хууль буюу гэрээгээр олгогдсон” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1.2 дахь заалтын “хуульд заасны дагуу бусдад” гэснийг “худалдахаас бусад хэлбэрээр” гэж өөрчлөх. Санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан 2 санал байна.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтад доор дурдсан агуулгатай тайлбар нэмэх:

“Тайлбар:энэ заалт нохой салхилах зориулалтын талбайд хамаарахгүй.” Санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “нохой, муур төрснөөс хойш зургаагаас арван хоёр сарын дотор” гэснийг “нохой, мууранд” гэж, мөн зүйлийн 9.2.5 дахь заалтын “ялгадсыг” гэснийг “өтгөн ялгадсыг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 9.4 дэх хэсэг нэмэх:

“9.4.Энэ хуулийн 9.2.3-т заасан үүрэг Монголын үндэсний уугуул үүлдрийн нохойны асран хамгаалагчид хамаарахгүй.” Санал хураалт. Минийх ороогүй байна.

Миний санал сая орсонгүй. Уг нь дэмжсэн. Санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. 54.5 хувиар санал хураалт хүчингүй боллоо. Санал хураалт. Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Дарга аа, сая санал хураалт дээр энэ тоног төхөөрөмж ажиллахгүй байна. Дахин санал хурааж өгөхийг хүсье. Энэ саналыг хүчингүй болгоод, дахин санал хураах горимын санал гаргаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Дамдинням гишүүний саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдэж, санал хураалт хүчингүй боллоо. Санал хураалт. 54.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан 2 санал байна.

Төслийн 10 дугаар зүйлийн “Нохой, муурын нэгдсэн бүртгэл” гэсэн гарчгийг “Нохой, муурыг бүртгэлд хамруулах, бичил чип суулгах” гэж өөрчилж, 10.1, 10.2 дахь хэсгийн “сум,” гэснийг тус тус хасаж, 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Нохой, муурын хаягийн бүртгэл нь асран хамгаалагчийн байнга оршин суугаа газрын хаягаар, нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах байрын оршин байгаа газрын хаягаар тус тус тодорхойлогдоно.” Санал хураалт. 45.5 хувиар санал дэмжигдсэнгүй. Ганболд гишүүн санал гаргах уу.

Г.Ганболд: Дэмжсэн санал өгсөн. Төхөөрөмж ажиллахгүй байна. Санал хураалтыг хүчингүй болгож өгөх санал хураалт явуулахыг хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Ганболд гишүүний саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 45.5 хувиар санал дэмжигдсэнгүй. Төхөөрөмжүүд ажиллахгүй байна даа. Төхөөрөмж засъя. Техникийнхэн анхаараарай.

Ганболд гишүүний гаргасан саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ. Санал хүчингүй боллоо. Санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.7, 10.8 дахь хэсэг нэмэх:

“10.7.Энэ хуулийн 40.1.4-т заасан нохой, муурын нэгдсэн бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журамд дараах асуудлыг тусгана:

10.7.1.бичил чип суулгасан нохой, муурын асран хамгаалагчийн бүртгэл;

10.7.2.нохой, муур
үржүүлэгч болон түр байрлуулан
асрамжлах газрын бүртгэл;

10.7.3.нохой, муурын асран
хамгаалагчийн сургалт явуулах хуулийн
этгээдийн бүртгэл;

10.7.4.алдагдсан нохой,
муурын бүртгэл.

10.8.Баг, хорооны Засаг дарга,
нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллага, мал эмнэлгийн үйлчилгээний
нэгж нь бичил чип унших төхөөрөмжтэй
байна.” Санал хураалт. 45.5 хувиар санал
дэмжигдсэнгүй.

Идэрбат гишүүнийх
ажилласангүй юу. Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Дэмжсэн санал өгсөн
боловч эсрэг гарлаа.Тэгээд саяын санал
хураалтыг хүчингүй болгож өгөх
горимын санал гаргаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Идэрбат
гишүүний гаргасан саналын дагуу саяын
санал хуралтыг хүчингүй болгох санал
хураалт. 54.5 хувиар санал хүчингүй
боллоо.

Санал хураалт. 54.5 хувиар санал
дэмжигдлээ.

Хуулийн төслийн 11 дүгээр
зүйлтэй холбогдуулан асуулт асуух
гишүүд байна уу. Алга байна. Хуулийн
төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан
2 санал байна.

13.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1
дэх хэсгийн “Асран хамгаалагч энэ
хуулийн 10.1.2, 10.2.1-д заасан
үндэслэлээр” гэснийг, 11.2 дахь хэсгийн
“Сум,” гэснийг тус тус хасах. Санал
хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 11 дүгээр зүйлд доор
дурдсан агуулгатай 11.2 дахь хэсэг
нэмэх:

“11.2.Хот, сууринаас бусад
газарт нохой, муурын асран
хамгаалагчаар бүртгүүлэхэд энэ хуулийн
11.1.3 дахь заалт хамаарахгүй.” Санал
хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 12 дугаар
зүйлтэй холбогдуулан асуулт асуух
гишүүд байна уу. Алга байна. Хуулийн
төслийн 12 дугаар зүйлд 1 санал байна.

15. Төслийн 12 дугаар зүйлийг
хасах. Санал хураалт. Минийх
ажилласангүй. 45.5 хувь болоод санал
уначихлаа. Миний төхөөрөмж
ажилласангүй. Дахин санал хурааж
хүчингүй болгоё гэсэн санал гаргаж
байна. Санал хураалт. Минийх ерөөсөө
ажиллахгүй байна.

Техникээ анхаараарай. Минийх
ерөөсөө ажиллахгүй байна. Тэгвэл
горимын санал гаргая. Төхөөрөмж
ажиллахгүй, доголдоод байгаатай
холбогдуулаад горимын санал хэн гаргах
вэ. Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Дарга аа, энэ санал
хураалтууд дээр бид нарын бүгдийн
тоног төхөөрөмж ерөөсөө ажиллахгүй
байна. Гацаад байх шиг байна. Тэгээд
горимын санал гаргая. Гар өргөж хураая.
Дэгийн хуулийн дагуу боломжтой учраас
гар өргөж хураагаад явбал арай шуурхай
болох гээд байна. Тэгэхгүй бол саналууд
энэ тоног төхөөрөмжөөс болоод унаад
байна.

Ж.Бат-Эрдэнэ: Дамдинням
гишүүний гаргасан саналын дагуу гар
өргөж хураая гэсэн санал хураалт
явуулъя. Гар тооллого явуулъя гэсэн
санал хураалт явуулъя. Санал хураалт.
Ажиллахгүй байна. Тэгэхээр гар өргөөд
санал хураачихъя. 11 гишүүнээс 6 гишүүн
дэмжиж горимын санал дэмжигдлээ.

Үүнээс хойш гар өргөж санал
хураалт явуулна. Санал хураалт. 11-ээс 6
гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.
Түрүүний саналыг хураан. Уншсан

байгаа. Санал хураалт. 11 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ. 11-ээс 7 юм байна шүү.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Энэтэй холбоотой 2 санал байна.

16. Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсгийн “сум, дүүргийн” гэснийг “нутаг дэвсгэр хариуцсан” гэж өөрчилж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “эрх бүхий этгээдэд” гэсний дараах “гэрийн тэжээвэр амьтныг” гэснийг хасаж, мөн зүйлийн 14.4 дэх хэсгийн “тухайн амьтныг” гэсний дараа “олох,” гэж нэмэх. Санал хураалт. 11-ээс 7 гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

17. Төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийг хасах. Санал хураалт. 11 гишүүнээс 7 гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдолтой 1 санал байна.

18. Төслийн 15, 16 дугаар зүйлийг нэгтгэн 15 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл. Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

15.1. Нохой, муур үржүүлэх үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан ашигийн төлөө хуулийн этгээд эрхлэнэ.

15.2. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны

байгууллага энэ хуулийн 41.1.2-т заасны дагуу нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгоно.

15.3. Энэ хуулийн 15.2-т заасан зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлийг тодорхой зааж бичгээр хариу өгнө.

15.4. Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

15.4.1. зөвшөөрөл хүссэн өргөдөл;

15.4.2. энэ хуулийн 21.1.1-д заасан шаардлага хангасан нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны хэмжээ, нөхцөл байдлыг харуулсан гэрэл зураг, хаягийн нотлох баримт;

15.4.3. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар;

15.4.4. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

15.4.5. үржүүлэх нохой, муурын төрөл, үүлдэр, хүйс, тоо толгой, чипний дугаарын мэдээлэл.

15.5. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны нөхцөл байдалтай биечлэн танилцах эрхтэй.

15.6. Энэ хуулийн 41.1.5-д заасан нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх журамд дараах зүйлийг тусгана:

15.6.1. нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээлэл;

15.6.2.нохой, муурын
үүлдэр;

15.6.1нохой, муурын
үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон
байрны эрүүл ахуйн шаардлага.” Санал
хураалт. Санал хураалтыг хүчингүй
болгоё. Туваан гишүүн. Санал хураалтыг
цуцлъя. Туваан гишүүн.

Ц.Туваан: Зарчмын зөрүүтэй
санал дараа нь байгаа тийм үү. Тэр
дараа нь биз дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Төгсгөл дээр нь.
Санал хураалт. 11-ээс 7 гишүүн
дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 16 дугаар
зүйлтэй холбогдуулан асуулт асуух
гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 17 дугаар
зүйлтэй холбогдуулан асуулт асуух
гишүүд байна уу. Алга байна.

Төслийн 17 дугаар зүйлийг хасах.
Санал хураалт. 11-ээс 7 гишүүн
дэмжиж, 8 гишүүн үү. 8 гишүүн
дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 18 дугаар
зүйлтэй холбогдуулан асуулт асуух
гишүүд байна уу. Алга байна. Хуулийн
төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан
1 санал ирсэн.

20. Төслийн 18 дугаар зүйлийн
18.1.1 дэх заалтын “энэ хуулийн 16.4-т
заасны дагуу ирүүлсэн зөвшөөрөл хүссэн
өргөдөл, түүнд хавсаргасан” гэснийг
“энэ хуулийн 15.4-т заасны дагуу
ирүүлсэн” гэж өөрчлөх. Санал хураалт.
11 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал
дэмжигдлээ.

Хуулийн төслийн 19 дүгээр
зүйлтэй холбогдуулан асуулт асуух
гишүүд байна уу. Алга байна. Хуулийн
төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан
1 санал байна.

21.Ажлын хэсгийн гаргасан,
Төслийн 19 дүгээр зүйлийг хасах. Санал
хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал
дэмжигдлээ.

Хуулийн төслийн 20 дугаар
зүйлтэй холбогдуулан асуулт асуух
гишүүд байна уу. Зарчмын зөрүүтэй
санал алга байна.

Хуулийн төслийн 21 дүгээр
зүйлтэй холбогдуулан асуулт асуух
гишүүд байна уу. Алга байна. Хуулийн
төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулан
ажлын хэсгээс 1 саналын томъёолол
бэлдсэн.

22. Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2
дахь хэсгийн “асран хамгаалагчийн
үүргийг” гэснийг “үүргийг асран
хамгаалагчийн нэгэн адил” гэж өөрчилж,
мөн зүйлийн 21.1.5 дахь заалтыг доор
дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.5.хүүхдийн цэцэрлэг,
бүх шатны сургууль, сургуулийн дотуур
байр, эмнэлэг, сувиллаас 200 метрийн
дотор нохой, муур үржүүлэх үйл
ажиллагаа явуулахгүй байх;” Санал
хураалт. 11 гишүүнээс 8 гишүүн
дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 22 дугаар
зүйлтэй холбогдуулан асуулт асуух
гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 23 дугаар
зүйлтэй холбогдуулан асуулт асуух
гишүүд байна уу. Алга байна. Хуулийн
төслийн 23 дугаар зүйлтэй холбогдуулан
1 санал ирсэн.

23. Төслийн 23 дугаар зүйлийн
23.1.8 дахь заалтыг хасаж, мөн зүйлд
доор дурдсан агуулгатай 23.2 дахь хэсэг
нэмэх:

“23.2.Нохой, муур үржүүлэх үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дуусгавар
болсон тохиолдолд зөвшөөрөл эзэмшиж
байсан этгээд нохой, муур үржүүлэх үйл

ажиллагааг нэн даруй зогсоож, хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй нохой, муурыг иргэн, эсхүл энэ хуульд заасан зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд шилжүүлнэ.” Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 24 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 24 дүгээр зүйлтэй холбоотой 1 санал байна.

24.Төслийн 24, 25 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. 11 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 25 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 26 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 26 дугаар зүйлтэй холбогдуулан 1 санал байна.

25.Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “Нохой, муурыг төрснөөс хойш 45 хоногийн” гэснийг “Нохой, муурын үр төлийг 60 хоногийн” гэж өөрчилж, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.2.Нохой, муур үржүүлэгч нохой, муурын үр төлийг төрснөөс хойш гурван тун урьдчилан сэргийлэх тарилга болон туулгалтад хамруулсны дараа бусдад шилжүүлнэ.” Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 27 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 2 санал ирсэн байна.

26.Төслийн 27 дугаар зүйлийн 27 дахь хэсгийг энэ зүйлийн 27.1 дэх хэсгийн тайлбар болгон өөрчлөх. Санал хураалт.

11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

27.Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.4 дэх хэсэг нэмэх:

“27.4.Энэ хуулийн 41.1.6-д заасан эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэхэд дагаж мөрдөх журамд дараах зүйлийг тусгана:

27.4.1.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээлэл;

27.4.2.түр байрлуулан асрамжлах газрын хөтлөх бүртгэл;

27.4.3.түр байрлуулан асрамжлах газар гэрийн тэжээвэр амьтан хүлээн авах, шилжүүлэх талаарх мэдээлэл.” Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 28 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал ирсэн байна.

28.Төслийн 28 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 29 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

29.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “энэ хуулийн 17.1-17.4-т” гэснийг “энэ хуульд” гэж, мөн зүйлийн 29.3.1 дэх заалтын “энэ хуулийн 28.2-т заасны дагуу ирүүлсэн” гэснийг “эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 29.4 дэх хэсэг нэмэх:

“29.4.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа явуулах орон байрны нөхцөл байдалтай биечлэн танилцах эрхтэй.” Санал хураалт. 11 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 30 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 30 дугаар зүйлтэй холбогдуулан 1 санал байна.

30.Төслийн 30 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. 11 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 31 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 32 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 32 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс 1 санал ирсэн.

31.Төслийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “асран хамгаалагчийн үүргийг” гэснийг “үүргийг асран хамгаалагчийн нэгэн адил” гэж өөрчлөх. Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 33 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 34 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс 1 санал ирсэн.

32. Төслийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.3.Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллаас 400 метрийн дотор эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 35 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Хуулийн төслийн 36 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 37 дугаар холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал ирсэн.

33.Төслийн 37, 38 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 38 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 39 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 40 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 40 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс 1 санал ирсэн.

34.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтын “тухайлан тусгаж хэрэгжүүлэх;” гэснийг “тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавих;” гэж, 40.1.3 дахь заалтын “боловсруулах” гэснийг “батлах;” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 40.1.4 дэх заалт нэмэх:

“40.1.4.Нохой, муурын бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга болон Цагдаагийн байгууллагын саналыг авч батлах.” Санал хураалт. Асуулт уу. Батжаргал гишүүн асуулт.

Ж.Батжаргал: Энэ 40.1.4 дэх заалт л даа. Энэ сан бүрдүүлэх, хөтлөх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга цагдаагийн байгууллагын саналыг авч баталж байх хэрэг байгаа юм уу. Энэ санг чинь хөтлөх бүх юмыгтэр мал эмнэлгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь нэгдсэн дүрмээрээ батлаад, тэрийгээ улсын хэмжээнд 1 мөр хэрэгжүүлээд явбал яасан юм.

Хоёрдугаарт, түрүүн асуух гээд асууж чадалгүй өнгөрөөсөн юм. Үржүүлгийн газрыг нь болохоор сургууль, цэцэрлэгээс 200 метр дотор хийхгүй, түр асрамжлах газрыг нь 400 гээд 2 өөр тоо яваад байна. Тэгэхээр тэр үржүүлгийн газар чинь яахаараа түр асрамжлах газар байж болдоггүй юм. Тийм учраас 1 ижил хэмжээс заах хэрэгтэй болчихож байгаа байхгүй юу.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг Цогтбаатар гишүүн хариулъя.

Д.Цогтбаатар: Тэр цагдаа Засаг даргаас санал авч, гэхдээ тэр журмыг боловсруулах газар чинь мал эмнэлгийн газар нь боловсруулахаар заасан байгаа. Тэгээд 40 дүгээр зүйлд энийг бүр тодорхой заагаад өгсөн. Зүгээр тэр журмыг батлахдаа Засаг дарга, цагдаагийн газраас яагаад санал авах хэрэгтэй гэхээр, зүйгээр санал авна. Яагаад гэхээр яг амьдрал дээр тухайн нөхцөл байдал яах аргагүй тэд нараас санал авах юмнууд зөндөө гарна. Нөгөө талаас тэнд байгаа газрууд чинь өөрсдөө тэр чипийг унших тоног төхөөрөмжтэй байх ёстой гээд бас журамлаад өгчихсөн. Ингээд хоорондоо уялдах юм. Яагаад гэвэл энэ газрууд чинь бас огт нохой муурыг хариуцахгүй биш,

хариуцаж байгаа. Тэгэхээр зүгээр тэндээс санал авч журмаа боловсруулахдаа л хийнэ гэдэг үүднээс явж байгаа.

Тэр 400, 200 дээр манайхан хариулт өгнө. Яах вэ, нохой, ер нь гэрийн тэжээвэр амьтныг үржүүлэх, асрамжлах газар 2 бол жинхэнэ хоорондоо тусдаа байгууллага. Үржүүлнэ гэдэг бол үнэхээр шинжлэх ухааны селекцийн маягтай үйл ажиллагаа явуулж байгаа шүү дээ. Асрамжлах чинь бол түр хугацаанд гээгдчихсэн нохой эд нарыг эсхүл эзэнгүй байгаа нохойг түр хугацаанд асрамжилж байгаад дараагийн эзэнтэй болтол нь харах газар байхгүй юу. Тэр бол зохицуулалт арай өөр байгаа. Манай ажлын хэсгийнхэн өөрсдөө хариулна биз энэ дээр.

Ж.Бат-Эрдэнэ: Батжаргал гишүүн дахин асууя. Тодруулъя.

Ж.Батжаргал: Хэдүүлээ ингэмээр байна. Бид чинь төрийн байгуулалтынхаа хувьд нэгдсэн бодлоготой байх ёстой. Нэгж болгон дээр өөр өөр дүрэм журам батлаад байж боломгүй л байна л даа. Улсын хэмжээнд нэг дүрэм журам л баталъя. Тэрийгээ нэг мөр хэрэгжүүлбэ. Тийм учраас Засаг дарга нараар биш, мал амьтны эрүүл мэндийн асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллага нь батлаад л тэрийгээ нэг мөр хэрэгжүүл.

Хоёрдугаарт, үржүүлгийг түр байлгах гээд 2, 3 салгаад хэрэггүй. Тэр үржүүлгийн газар нь шаардлагатай тохиолдолд тэр эзнээсээ төөрсөн юмыг төр өөр дээрээ байлгаад эзнийг нь олж өгдөг юмыг нь давхар нээе л дээ. Тэгээд хэний нохой төөрөөд ирэх бол гээд нэг тийм стандарт хангасан юм байгуулчихаад хүн хоосон сууж байх юм бий. Тийм учраас ерөөсөө Зууланг нь эрхэлж болохоор, тэр чинь бүр түр л байхгүй юу. Тийм учраас тэр үржүүлгийн газар дээрээ байх ёстой.../минут дуусаа/

Ж.Бат-Эрдэнэ: Тэгээд тусдаа байр байх юм байна. Ажлын хэсэг Цогтбаатар гишүүний микрофон.

Д.Цогтбаатар: Манайхан энэ дээр гүйцээгээд хариулаарай. Зүгээр асрамжлах үржүүлэх 2 бол жинхэнээсээ 2 өөр. Одоо лав л миний мэдэх тэр гаднын юун дээр бол бүр эзэнтэй болтол нь харж хандаж байх газрууд чинь үнэхээр өөр байдаг юм. Тэр чинь бол амьтан аваад түр байлгаж байгаад эзэнтэй болгох тухай асуудал байхгүй юу. Нөгөөх нь бол бүр үржүүлээд өөрөө селекцийг нь явуулж байгаа газар үнэхээр өөр. Зүгээр нэг нохой түр байлгаж байгаад эзэнтэй болох, нөгөөх нь үржүүлээд явах 2 чинь бол тусдаа ажил шүү. Гэхдээ манайхан энэ дээр хариулаач.

Ж.Бат-Эрдэнэ: Мэргэжлийн дагуу нэг байж болохгүй юм уу. Ажлын хэсэг 3 номер.

Ц.Зориглон: Азтай савар төрийн бус байгууллагын тэргүүн Зориглон байна. Энэ дээр бол нохой, муур үржүүлгийн газар гэдэг бол яг нөгөө цэвэр үүлдрийн тэр санаачлагаараа өөрөө үржүүлж байгаа үйл ажиллагаа явагдаж байгаа. Тэр дээр бол вакцин, туулга, бүх шинжилгээ ариун цэврээ хариуцаад тэнд үржүүлэг хийж байгаа ашгийн төлөө байгууллага. Асрамжлах газар гэдэг бол яг гудамжнаас гэмтэж бэртсэн юм уу, яг манай Монголын өвлийн хүйтэнд авраад тэжээж байгаа эзэн олдтол нь байлгаж байгаа тийм газрыг хэлж байгаа юм. Тэгэхээр одоо манай Монголд байдаг хэд хэдэн сайн дураараа энэ үйл ажиллагааг явуулж байгаа байгууллагууд байгаа л даа. Хамгийн гол нь энийг яагаад ингэж зөрүүтэйгээр орон зайг нь зааж өгсөн бэ гэхээр үржүүлгийн газар бол ариун цэврээ өөрсдөө хангалттай хангаад явж байдаг. Асрамжийн газар бол гудамжнаас энд тэндээс олдож байгаа учраас ямар нэгэн вирус юм уу, ямар нэгэн халдварт өвчинтэй байх магадлал өндөртэй учраас бид нар сургууль,

цэцэрлэгийн орчноос илүү зайтай байлгая гэж оруулж өгсөн байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Наад асрамжлах гэдэг үг чинь ер нь зөв юм уу. Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүн асуугаад байна л даа. 40.1.4 гээд.

Нохой, муурын бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга болон Цагдаагийн байгууллагын саналыг авч батлах гээд бичсэн байна. Сумд яах юм. Аймаг руугаа явах уу. Тэгээд аймагт очиж аймгийн Засаг даргаараа ингээд энийг жаахан өөрчлөхгүй бол. Одоо тухайлбал Замын-Үүд ч гэдэг юм уу, Бор-Өндөр ч юм уу цагдаагийн хэлтэстэй. Ер нь сум орон нутагт ч гэсэн нохой бол сүүлийн үед их тэжээж байна шүү дээ. Тэгэхээр энийг жоохон хялбаршуулаад аймаг, нийслэл ч гэдэг юм уу, сум, дүүрэг ч гэдэг юм уу Засаг дарга, тухайн шатны цагдаагийн байгууллагын саналыг авч батлах ч гэдэг юм уу ийм үгээр оруулахгүй бол сумт нохой тэжээчихээд тэгээд аймаг руу яваад аймгийн Засаг даргын саналыг авдаг. Аймгийн цагдаагийн байгууллагын саналыг авдаг гээд ийм шат дараатай болчихоод байна. Тэгэхээр сум, дүүрэг гэдэг нэрийг нь оруулж болохгүй юм уу гээд.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгвэл энийг саяын гишүүдийн хэлснээр найруулгатайгаар авъя. Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 41 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал байгаа.

35.Төслийн 41 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41 дүгээр зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

41.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэрийн тэжээвэр амьтны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

41.1.1. нохой, муурын нэгдсэн бүртгэл хөтлөх, бүртгэлийн систем хөгжүүлэх;

41.1.2. нохой, муур үржүүлэх болон эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хугацааг сунгах;

41.1.3. нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын нэгдсэн бүртгэл хөтлөх;

41.1.4. нохой, муур үржүүлэх болон эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа энэ хуульд заасан шаардлага, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

41.1.5. нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах, түүний биелэлтийг хангуулах;

41.1.6. эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах, түүний биелэлтийг хангуулах;

41.1.7. нохой, муурын асран хамгаалагчийн сургалт зохион байгуулах хуулийн этгээдийг бүртгэх;

41.1.8. нохой, муурыг түр байрлуулан асрамжлах газрын эрүүл ахуйн хөтөлбөрийг бүртгэж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

41.1.9. гэрийн тэжээвэр амьтны тухай хууль тогтоомжийг сурталчлах, гэрийн тэжээвэр

амьтантай холбоотой иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх ажлыг тасралтгүй явуулах.

41.2. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 20.2, 31.2-т заасан мэдээллийг нийтэд ил тод мэдээлнэ.” Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 42 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. 1 санал байна.

36. Төслийн 42 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 43 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. 1 санал байна.

37. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “бүртгэл хөтлөх,” гэсний дараа “бичил чип унших төхөөрөмжөөр” гэж нэмэх. Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 44 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал байна.

38. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “хууль тогтоомжийн” гэснийг “хууль тогтоомжийг сурталчлах,” гэж, 44.1.2 дахь заалтын “бүртгэл хөтлөх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах” гэснийг “үржлийг хязгаарлах, бичил чип суулгах ажлыг зохион байгуулах.” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 44.1.4 дэх заалтыг хасах. Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ. 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 45 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух

гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 46 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 47 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: 47.2.9 дээр ингэсэн байна. Гэрийн тэжээвэр амьтны хөдөлгөөнийг хязгаарласан орчинд байнга уях, хорихыг хориглоно гэсэн. Энэ чинь зөрчилдөхгүй юу. Хашаандаа нохойгоо уях, энийг чинь хүчирхийлэл гээд үзчих юм биш үү. Энийг тайлбарлаад өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг. 3 дугаар микрофон. Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Энэ хорих дээр ингэж байгаа юм. Энэ нохойг тэжээж байхдаа хашаанд нохой уях гэдэг бол энд хамрагдахгүй. Яагаад гэвэл энэ чинь ингэж байгаа байхгүй юу. Нохой муурыг байнга уях, хөдөлгөөн хязгаарласан орчинд гээд. Хашаанд гэдэг чинь хэр баргын амьтан байхад хамаагүй том орчин байхгүй юу. Тодорхой тэжээж байх хугацаандаа айл ямар ч айл нохойгоо байнга уяатай байлгаад байдаггүй чөлөөтэй байлгадаг шүү дээ. Хүн амьтан орж ирж байгаа үед нь уяж байгаа. Энэ чинь бол нохой, мууртай зэрлэгээр харьцаад жишээлбэл, уячихаад ямар ч үед эргээд тавихгүй байгаа тийм харьцаж байгааг хорьж байгаа байхгүй юу. Түүнээс өөр юугаар бол энийг хориогүй. Манайхан бас энэ дээр тодотгол өгнө биз. Жишээлбэл, энд гол үг нь тэр хөдөлгөөнийг хязгаарласан орчинд гэж байгаа шүү дээ. Манай хашаа эд нарт бол энэ хөдөлгөөнийг хязгаарласан орчин гэдэг ойлголт хашаань бол яагаад ч байх боломжгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 2 дугаар микрофон.

Н.Баясгалан: Сайн байна уу. Өмгөөллийн Легал гайд хуулийн фирмийн эрх зүйч Баясгалан байна. Тэгэхээр гишүүний асуултад хариулъя.

Манай хуулийн 9.2.8 дээр гэр хороолол, амьны орон сууц, зуслангийн хашаанд нохойг уях тохиолдолд зориулалтын хүзүүвч, 3 метрээс багагүй урттай гүйлгэх уяа ашиглах гээд энэ зохицуулалт орж ирсэн байгаа. Ажлын хэсгийн даргын хэлсэнчлэн яг тухайн орчиндоо байнга хорьж байгаа нөхцөл байдал өөрөө хүчирхийлэлт хамаарна. Гэр хороолол, орон сууцны байшинд уях нь бол өөрөө хүчирхийлэл бол биш гэж үзэж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: 3 метрээс бага байж болохгүй юм уу. Ажлын хэсэг 2 дугаар микрофон.

Н.Баясгалан: Тэгэхээр хуулийн төслийн 9.2.8 дахь заалт маань олон улсынхаа жишгийн дагуу уяаны шаардлагыг бол зааж өгсөн байгаа. Энэ нь эргээд нөгөө амьтанд өөрөө хүчирхийлсэн зан авиртай болохгүй байх, нийгэмд аюултай зан авиртай болохгүй байхаас сэргийлж өгч байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ойлголоо. Хуулийн төслийн 47 дугаар зүйлтэй холбогдуулан I санал байна.

39.Төслийн 47 дугаар зүйлийн 47.2.1 дэх заалтын “харгис хэрцгийгээр” гэснийг хасаж, 47.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.2.3.эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах, гэрийн тэжээвэр амьтан нь эдгээшгүй өвчин, гэмтэлтэй, орчин тойрондоо аюултайгаас бусад тохиолдолд унтуулга хийх;” II-ээс 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 48 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 49 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 50 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал байна.

40.Төслийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсгийн “шагнал” гэсний өмнө “сугалаа” гэж нэмэх. Санал хураалт. 11-ээс 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 51 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал байна.

41.Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэснийг хасах. Санал хураалт. 11-ээс 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 52 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал байна.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал хураалт. 11-ээс 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

43.Төсөлд доор дурдсан агуулгатай 52.2 дахь хэсэг нэмэх:

“52.2.Энэ хуулийн 12.4 дэх хэсгийг Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг хэрэглэх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хугацаанаас хойш мөрдөнө.”

44.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх. Санал хураалт. 11-ээс 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

1.Төслийн 3.1.7 “энэ хуульд заасан журмын дагуу” гэснийг “энэ хуульд заасны дагуу”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “зүйлийн 18.1-т заасан эхний” гэснийг “хуулийн 18.1-т заасан бүртгэлийн” гэж өөрчлөх. 11-ээс 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл.

Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.12 дахь заалт нэмэх:

“3.1.12.Удмын бичиг гэж цэвэр үүлдрийн нохойны дэлхийн байгууллагын албан ёсны гишүүн байгууллагаас олгодог уг амьтны гарал үүсэл, эцэг эх, төрсөн огноо, хүйс, үүлдэр зэргийг заасан бичиг баримт” Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

45.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.4.6 дахь заалт нэмэх:

“15.4.6. нохойны хувьд цэвэр үүлдрийн тодорхойлох удмын бичиг.” Санал хураалт. 11-ээс 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Одоо хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Нэг.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын томъёолол бэлтгэсэн 2 санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Нохой, эсхүл мууранд “гэснийг “Гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч, түр харагчийн нохой, мууранд” гэж өөрчилж, “бусад” гэсний дараах “гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч, түр харагчийн” гэснийг хасах. Санал хураалт. 11-с 8 гишүүн гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “нэг нохой, эсхүл мууранд” гэснийг “нохой, муур тус бүрд бичил” гэж өөрчилж, мөн зүйлийн 11 дэх хэсгийн “шагнал” гэсний өмнө “сугалаа,” гэж нэмэх. Санал хураалт. 11-с 8 гишүүн гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Нэг.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал ирсэн.

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дугаар зүйлийн “5.1.55” гэснийг “5.1.57” гэж, “17 дугаар зүйлд” гэснийг “14 дүгээр зүйлд” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 21 дүгээр зүйлийн “21.1.38” гэснийг “21.1.48” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. 11-8.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал ирсэн.

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.10 дахь” гэснийг “6.44 дэх” гэж, “7.17” гэснийг “6.15” гэж тус тус өөрчлөх. Санал

хураалт. 11-8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Долоо.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал ирсэн.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “бүртгээж эрхэлнэ.” гэснийг “бүртгээж эхэлнэ.” гэж өөрчлөх, төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.4-д заасны дагуу нохой, муурын бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журмыг энэхүү хууль хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дотор баталж, нохой, муурын бүртгэлийн системийг нэг жилийн дотор хөгжүүлж, ашиглалтад оруулна.” Санал хураалт. 11-с 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал ирсэн.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн “Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан” гэснийг “Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу” гэж өөрчлөх. Санал хураалт. 11-с 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 санал ирсэн байна.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай 9 дүгээр зүйл нэмэх:

“9 дүгээр зүйл. Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль хүчин төгөлдөр мөрдөхөөс өмнө үржил хязгаарлах мэс ажилбар хийлгээгүй найм болон түүнээс дээш настай нохой, муурын асран хамгаалагчид Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалт хамаарахгүй.” Санал хураалт. 11-с 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дууслаа.

15.02 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ